


Барилга, хот байгуулалтын сайдын
2019 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн
34 тоот тушаалын нэгдүгээр хавсралт



БЭЛЧЭЭРИЙН ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН УЛСЫН ХЯНАН БАТАЛГААНЫ АЖЛЫН АРГАЧИЛСАН ЗААВАР

Гарчиг	
НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	4
Ажлын үе шат ба ажилбарууд	4
1.БЭЛТГЭЛ АЖИЛ	7
1.1.Мэдээлэл цуглуулах	7
1.2.Нэгж талбар	9
1.3.Агаар, сансрын зураг ашиглах	11
1.4.Ажлын зураг	11
1.5.Мониторингийн цэг	12
1.6.Бичиглэлийн цэг	13
1.7.Бэлтгэл ажлын тайлангийн агуулга	13
1.8.Бэлтгэл ажлын захиалагчийн хяналт	15
ХОЁР.ХЭЭРИЙН СУДАЛГАА	15
2.1.Ярилцлагын судалгаа	15
2.2. Хянан баталгааны үзүүлэлтийг тодорхойлох	16
2.3. Бэлчээрийн доройтол	17
2.4. Бэлчээрийн газрын гадаргын төрх байдлын өөрчлөлт	22
2.5.Бэлчээрийн газрын гадаргын ба хөрсний бохирдол	25
2.6.Хээрийн ажлын тайлангийн агуулга	26
2.7.Хээрийн ажлын захиалагчийн хяналт	26
ГУРАВ. МАТЕРИАЛ БОЛОВСРУУЛАЛТЫН АЖИЛ	27
3.1.Үндсэн үзүүлэлт	27
3.2.Нөлөөллийн үзүүлэлт	28
3.3. Хянан баталгааны ажлын үндсэн мэдээллийг боловсруулах	29
3.4.Өмнө хийсэн хянан баталгааны үр дүнтэй харьцуулах	35
3.5.Мониторингийн цэгийн хувийн хэрэг бүрдүүлэх	35
3.6.Хянан баталгааны дүгнэлт бичих	35
3.7.Хянан баталгааны акт бичих	35

3.8. Нэгж талбарын сүлжээний зураг боловсруулах.....	36
3.8.1.Зураглах.....	36
3.8.2.Хүснэгтэн мэдээлэл оруулах	36
3.8.3.Зургийн эх бэлтгэх.....	37
3.8.4.Зураг хэвлэх	39
3.9.Хянан баталгааны ажлын тайлан.....	40
Тайлан бичих.....	40
Тоон файлыг хуулбарлах	42
3.10. Ажлын үр дүнг шалгах, хүлээн авах.....	43

Хавсралтууд:

Хавсралт 1. Монгол орны бэлчээр, хадлангийн ангилаа ба өнгөний код

Хавсралт 2. Геоботаникийн бичиглэлийн маягт

Хавсралт 3. Монгол орны хөрсний нэршил ба код

Хавсралт 4. Хөрсний бичиглэлийн маягт

Хавсралт 5. Хөрсний код бичих зааварчилгаа

Хавсралт 6. Хөрсний маршрутын судалгааны бичиглэл

Хавсралт 7. Мониторингийн цэгийн хувийн хэрэг

Хавсралт 8. Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны дүгнэлт

Хавсралт 9. Өмнөх хянан баталгааны үр дүнтэй харьцуулах

Хавсралт 10. Ажлын даалгаварын загвар

Хавсралт 11. Ажлын даалгавар бичих заавар

Хавсралт 12. Баталгааны хуудасны загвар

Хавсралт 13. Шаардлагатай стандартын жагсаалт:

1. Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код
MNS5641-0-2006 2х,
MNS5641-1-2006 6х,
MNS5641-2-2006 34х,
MNS5641-3-2006 47х
2. Бэлчээрийн газрын хөрсний элэгдэл эвдрэл, ургамлын талхлагдлыг тогтоох ерөнхий шаардлага. MNS 5546:2005
3. Хөрс.Хөрсний агро-химийн үзүүлэлтийг тодорхойлох. MNS 3310:1991.
4. Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд. MNS3298-1990
5. Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам. MNS 2305:1994.
6. Хөрсний нийт азот тодорхойлох арга. MNS3242-1989

7. Хөрс.Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга. MNS4006-1987
8. Хөрсний чанар. рН тодорхойлох. MNSISO10390-2001
9. Байгаль орчны бохирдол, бохирдлын хяналт ба хамгаалалт. Агаар, хөрсөн дэх пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS 6147:2010
10. Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS5850:2008
11. Хөрсний чанар. Органик хлорт пестицид ба полихлорт бифенилийн агууламжийг электрон баригч детектор бүхий хийн хроматографиар тодорхойлох арга. MNS ISO 10382-2012
12. Soil quality -Determination of content of hydrocarbon in the range c10-C40 by gas chromatography аргаар тодорхойлох. ISO 16703:2004
13. Ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр төрөл. MNS3985-87
14. Байр зүйн болон дэвсгэр зургийн загвар сан, таних тэмдэг. Масштаб 1:500, 1:1000, 1:2000, 1:5000. MNS 6702:2017
15. Байр зүйн зургийн загвар сан, таних тэмдэг. Масштаб 1:25000, 1:50000, 1:100000. MNS 6703:2017
16. Мета өгөгдлийн стандарт. MNS 5774

Ашигласан материал

1. Газрын бодлогын хүрээлэн, “Монгол орны бэлчээр, хадлангийн ангилаа”, 1992
2. П.Мягмарцэрэн “Газрын төлөв байдлын мониторинг”, 2005 он
3. Ц.Бадам “Монгол орны хөрсний нэршил ба код”, 2006 он
4. Ц.Бадам, Хөрсний код бичих зааварчилгаа, 2006 он
5. Х.Батнаран, “Монгол орны хадлан бэлчээр, таримал ургамалд хөнөөл учруулдаг царцаа”, 2015 он
6. Ундармаа, “Монгол орны бэлчээр, хадлангийн ангилааны өнгөний код”, 2018 он

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Газрын тухай хуульд заасны дагуу газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа нь газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах үйл ажиллагаанд төрийн хяналтыг тасралтгүй хэрэгжүүлэх зорилгоор газрын төлөв байдал, чанарын тогтвортой, гол үзүүлэлтүүдийг хууль тогтоомжид заасан хугацаанд давтан тодорхойлж улсын хяналтад авсан анхны үзүүлэлтүүдтэй харьцуулан дүгнэлт гаргахад оршино.
2. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг эрх бүхий мэргэжлийн байгууллага хийж, дүгнэлт гаргах бөгөөд газрын нэгдмэл сангийн бүх ангилалын газрыг 5 жилд нэг удаа газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаанд заавал хамруулж байхаар заасан байдаг.
3. Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлын зорилго нь бэлчээрийн газрын хөрс, ургамалжилтын төлөв байдал, шинж чанарыг тодорхой үзүүлэлтүүдээр гаргаж, бэлчээрт гарсан өөрчлөлтийг тодорхойлж, зураглан, дүгнэлт гаргах явдал юм.
4. Энэ аргачилсан зааврын зорилго нь бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг гүйцэтгэх, гүйцэтгэлд хяналт тавих, газрын төлөв байдал, чанарт гарсан өөрчлөлтийг тодорхойлох, дүн шинжилгээ хийх, тайлан бичиж дүгнэлт, зөвлөмж боловсруулах, хянан баталгааны мэдээллийн сан байгуулах ажлыг нэгдсэн аргачлалаар хангахад оршино.
5. Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлыг 3 үе шаттай гүйцэтгэх бөгөөд бэлтгэл, хээрийн судалгаа, материал боловсруулалтын үе шатуудаас бүрдэнэ. Ажлын үе шат, хийх ажилбаруудыг дараах хүснэгтээр тойм байдлаар үзүүлэв.

Ажлын үе шат ба ажилбарууд

Хүснэгт 1

1.Бэлтгэл ажлын үе шат	
1.1 Мэдээллийг цуглуулах, боловсруулах	
1	Байгаль-нутаг дэвсгэрийн нөхцөл, (физик-газарзүй, газрын гадарга, хөрс, уур амьсгал, ургамалжлын тархацургамалжлын тархац, худаг уст цэгийн байрлал, тэдгээрийн хүчин чадал), бэлчээрийн тэжээлийн нөөц, бэлчээр ашиглалтын судалгааны мэдээ, мэдээллийг цуглуулах;
2	Нийгэм-эдийн засгийн суурь нөхцлийн судалгааны хүрээнд бэлчээрийн талаар төрөөс болон орон нутагт хэрэгжүүлж буй бодлого чиглэл, цаашдын зорилтын талаар судалж тодруулах;
3	Урьд онуудад хийгдсэн хянан баталгааны нэгж талбарын сүлжээний зургийн ургамалжилт, төрх байдлыг судлан дүгнэлт хийж ажлын зэрэглэл тодорхойлох
4	Бэлчээрийн чиглэлээр гадаад, дотоодын эрдэм шинжилгээний байгууллага, төслүүдийн хийсэн судалгааны ажлын мэдээллийг цуглуулж байршлаар нь ажлын зурагт оруулах

1.2. Ургамалжлын хээрийн судалгааны ажлын зураг зохиох	
1	Судалгаанд хамрагдаж буй аймаг, сумдын хилийн цэсийг шалгах
2	Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын архиваас 1:100000 масштабтай тоон байр зүйн зураг бэлтгэх
3	Хянан баталгааны ажил хийхээс 4-5 жилийн өмнөх үүлгүй, 7-9 саруудад авсан хиймэл дагуулын зураг эсвэл тодорхой хугацааны агаарын зурагт боловсруулалт хийх
4	Өмнөх хянан баталгааны зурагт харуулсан сөөгжилт, чулуужилт, намагжилт, довон, доройтол, элсний нүүлт, автогений болон техногений нөлөө болон бусад шаардлагатай мэдээллийг агаар сансрын зураг мэдээллээр тодотгон харьцуулалт хийж, зурагт оруулах
5	Хортон мэрэгчид, паразит өвчний тархалтын талаарх мэдээллийг холбогдох газруудаас авч байршлаар нь ажлын зурагт оруулах
6	Өмнөх зурагт тэмдэглэгдсэн мониторингийн цэгүүдийг ажлын зурагт оруулах
7	Газрын нэгдмэл сангийн 1:100000 масштабын зурган болон тоон мэдээллээс улирлын бэлчээрийн хил зааг, өвөлжөө, хаваржаа, алслагдсан, ашиглалтгүй бэлчээрийн байршлыг ажлын зурагт оруулах
8	Мэдээллийг нэгтгэн ургамалжлын хээрийн судалгааны зургийг 1:100000 масштабтаар бэлтгэн судалгааны маршрутыг солбицолжуулах
1.3 Хөрсний хээрийн судалгааны зураг зохиох	
1	Урьд хийгдсэн хөрсний судалгааны материал, зургийг цуглуулан хянан баталгааны зурагтай давхцуулан хөрсний тодорхойлолт, төрх байдлын өөрчлөлтийг судлах
2	Хиймэл дагуулын мэдээллээс элсэн хөрстэй болон элс хуримтлагдсан газар, усны элэгдэл эвдрэлтэй газрын байршлыг тодруулан хөрсний зурагтай тулгаж, зураг байхгүй мэдээллийг оруулах
3	Өмнөх хянан баталгаагаар мониторингийн цэг сонгосон газруудын байршлыг зурагт оруулж, хөрсний нэршил, тархалтын хүрээг тодруулан зурах
4	Мэдээллийг нэгтгэн хөрсний хээрийн судалгааны зургийг 1:100000 масштабтаар бэлтгэн судалгааны маршрутыг солбицолжуулах
1.4. Удирдлага-зохион байгуулалтын ажил	
1	Хээрийн судалгааны зургийг үндэслэн хөрс, ургамалжлын тодруулгын судалгааны удирдамж боловсруулан зөвлөгөө, заавар, аргачлалаар хангах;
2	Мэдээллийг нэгтгэн хөрсний хээрийн судалгааны зургийг 1:100000 масштабтаар бэлтгэн судалгааны маршрутыг солбицолжуулах
2.Хээрийн судалгааны үе шат	
2.1. Ургамалжлын хээрийн судалгаа	
1	Бэлчээрийн ургамалжлын болон ургамалжлын тархацын төрх байдал (сөөгжилт, чулуужилт, намагжилт, довон, доройтол, элсний нүүлт ба хуримтлал)-ын

	судалгааг хийж, хил заагийг зурагт оруулах
2	Газрын гадаргын төрх байдлын ажиглалт хийж, хүчтэй, дунд талхлагдсан гэсэн ангилалд орсон талбаруудын хүрээ, шалтгаан нөхцлийг судлах
3	Хог болон хөнөөлтэй, хортой ургамал, ховор ургамлын тархалт, ургацад эзлэх хувийг тодорхойлох
4	Автогенийн нөлөөлөлд орсон газрын хил заагийг зурагт оруулах
5	Техногений нөлөөлөлд орсон газрын хил зааг, уурхайн овоолго, цооногийн байршлыг зурагт оруулах
6	Гадаргын болон гүний усашиглалтын байдлыг судлан байршлыг зураглах
7	Хортон мэрэгчдийн тархалтыг тогтоож зурагт оруулах
8	Халдварт ба паразит өвчний эх үүсвэр бүхий газрын байршлыг тогтоож зурагт оруулах
9	Мониторингийн цэг суулгах.
2.2. Хөрсний тодруулалтын судалгаа	
1	1:100000-ны масштабын зураглалын нарийвчлалыг хангах, хөрсний тодотгох судалгаа явуулж, хөрсний дээж авах
2	Хөрсний элэгдэл, эвдрэлийн зэргийг тодорхойлж зураглах
2.3. Газар ашиглалтын тодруулах судалгаа	
1	Газар ашиглалтын өөрчлөлтийг солбицолжуулан ашиглалтын зориулалтаар жагсаалт хөтлөх
3. Материал боловсруулалтын үе шат	
3.1 Хянан баталгааны нэгж талбарын сүлжээний зургийг боловсруулах	
1	Хээрийн судалгааны зурагт оруулсан бэлчээрийн ургамалжлын тархалтын хүрээ шугмыг тодруулах, өөрчлөн зураглах, бэлчээрийн индекс тавих, төлөв байдлын нөлөөллийн үзүүлэлт, дээж авсан болон мониторингийн цэг, нөлөөллийн үзүүлэлтүүдийг зурагт оруулах
2	Хээрийн судалгааны тодруулалтын дагуу бэлчээрийн тархалтын хил заагийг агаар сансрын зургийн мэдээллээр тодотгох
3	Зургийн топологи алдааг засварлах
4	Бэлчээрийн ургамалжлын код тавьж, нэгж талбаруудын атрибут мэдээллийг үүсгэх
3.2. Тайлан боловсруулах	
1	Ургацын дээжийг жигнэх, задлан шинжилгээнд өгөх
2	Бэлчээрийн хянан баталгааны нэгж талбарын сүлжээний зургийн тайлбар хүснэгтийг боловсруулах
3	Бэлчээрийн тэжээлийн нөөц, даац, багтаамжыг тооцож бэлчээрийн хүрэлцээ

	гаргах
4	Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлын тайлан бичих
5	Бэлчээрийн хянан баталгааны нэгж талбарын дүгнэлт (паспорт) бичих
3.3. Хөрсний зураг ба материал боловсруулах	
1	Хөрсний дээжийг задлан шинжилгээнд өгөх
2	Мониторингийн цэг орчмын хөрсний зураглал боловсруулж хувийн хэрэг хөтлөх, 1:100000-ны масштабтай хөрсний элэгдэл, эвдрэлийн зэргийг тогтоосон зураг гаргаж хянан баталгааны нэгж талбарын сүлжээний зурагт оруулах
3	Хөрсөн бүрхэвч, хөрсний шинж чанар, түүний өөрчлөлтийн талаар тайлан бичиж бэлчээрийн хянан баталгааны тайланд оруулах
3.4. Газар ашиглалтын судалгааны материалыг боловсруулах	
1	Газар ашиглалтын байдлыг зурагт оруулж газрын нэгдмэл сангийн ангилалын кодоор ангилах
2	Бэлчээр, хадлангийн газрын ашиглалтад тавигдах, үндсэн болон тусгай шаардлагыг тогтоож үүрэгжүүлэх.
3.5. Ажлыг хянуулах, хүлээлгэн өгөх	
1	Хянан баталгааны ажлыг захиалагч байгууллагад шалгуулах
2	Захиалагчаас шалгалт хийж холбогдох засварыг хийх
3	Захиалагч байгууллагын хурлаар хэлэлцүүлж, дүгнэлт гаргуулах
4	Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны зургийг хэвлэх, хүлээлгэн өгөх

1.БЭЛТГЭЛ АЖИЛ

1.1.Мэдээлэл цуглуулах

1. Төрөөс болон орон нутагт хэрэгжүүлж буй хүрээлэн буй орчныг хамгаалах болон бэлчээрийн газрын талаарх бодлого, шийдвэрийн баримт бичигт тусгагдсан цаашдын зорилтын талаар судалж тодруулна. Тухайн орон нутгийн газар ашиглалт, эзэмшилттэй холбоотой эрх зүйн акт, баримтын бүрдэлт, ашиглалт хамгаалалтын онцлогийг судлан, мэдээллийг нэгтгэнэ.
2. Хөрс, ургамалжлын тархац, түүний онцлогтой холбогдох судалгаа шинжилгээний материалтай танилцаж тэмдэглэл хөтөлнө.
3. Бэлчээртэй холбоотой статистик мэдээ (малын тоо, усан хангамж, жилийн дундаж ургац), газрын нэгдмэл сангийн тайлан, бусад шаардлагатай тоо баримт, өвөл, хаврын бэлчээрийн хил зааг, гэрээгээр ашиглуулсан бэлчээрийн хил зааг, малчдын бүлгийн болон өвөлжөө хаваржааны байршлыг нэгж талбарын зурагтай давхцуулна.

4. Өмнөх хянан баталгаа хийгдсэнээс хойших байгаль, цаг уурын өөрчлөлтийн мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийж, ажлын зурагт оруулна.
5. Өмнө хийгдсэн бэлчээр, хадлангийн судалгаа, хянан баталгааны ажлын мэдээллүүдийг харьцуулан судалж, урьдчилсан байдлаар үнэлэлт дүгнэлт өгнө.
6. Гадаад, дотоодын эрдэм шинжилгээний байгууллага, төслийн хүрээнд тухайн нутаг дэвсгэрт бэлчээртэй холбоотой хийгдсэн судалгааны ажлын тайлан, зургийг харьцуулан дүн шинжилгээ хийж, ажлын зурагт оруулна.
7. Нэн ховор, ховор болон тэжээлийн ач холбогдолтой ургамал байгаа эсэх талаар холбогдох байгууллагуудаас мэдээлэл авч, ажлын зурагт оруулна.
8. Агаар, сансрын зургаас ургамалжлын тархац, хөрсөн бүрхэвчийн төлөв байдал, элс хуримтлагдсан газар, усны элэгдэл эвдрэлтэй газар, авто зам гарсан газар, газрын гадаргын механик өөрчлөлт, уул уурхай, физик-геологийн үйл явц үзэгдлийн тархалт, гадаргын усны байршлыг ажлын зурагт оруулна.
9. Нэгж талбар дотор, гадны нөлөөгөөр үүсч бий болсон хөрсний элэгдэл, эвдрэл, зулгаралт, газрын гадаргуугийн өөрчлөлт, бохирдолт, уурхайн овоолго, цооног болон ургамлан нөмрөгийн талхлагдал зэрэг гадны хүчин зүйлийн нөлөөлөл, физик-геологийн үйл явц, үзэгдлийн байршлыг ажлын зурагт тэмдэглэсэн байна.
10. Агаар, сансрын зураг, газар ашиглалт, хөрс ургамлын зураглал, газрын нэгдмэл сангийн бүртгэл зэргийг үндэслэн хянан баталгааны нэгж талбарын тоо, талбайн хэмжээг тоймлон тодорхойлно.
11. Бэлтгэл ажлын хүрээнд хөрс, ургамлын зураг, газар ашиглалтын төрөл, нягтаршлыг харгалзан бичиглэл, дээж авах цэг, мониторингийн (хяналтын) цэгийг урьдчилан төлөвлөх бөгөөд цэгийн байршил, солбицолыг ажлын зурагт оруулна.
 - Бичиглэлийн цэг дээр зүйлийн бүрэлдэхүүн, ургамлын бүрхэц, ургац тодорхойлно.
 - Дээж авах цэг дээр хөрсний малталт хийх, хөрсний дээж авна.
 - Мониторингийн цэгт дээрх бүх ажилбар хийгдэнэ.
12. Хээрийн ажил гүйцэтгэх багийг бүрдүүлж, томилолт, унаа, зөвлөгөө, удирдамжаар хангах бөгөөд хээрийн судалгаа хийх маршрутыг ажлын зурагт оруулсан байна.
13. Хянан баталгааны ажилд аймгийн газрын асуудал эрхэлсэн байгууллагын мэргэжилтэн, сумын газрын даамлыг заавал оролцуулах тул гүйцэтгэгч хээрийн судалгаа эхлэхээс өмнө холбогдох газарт мэдэгдэж, оролцох мэргэжилтэн, албан тушаалтныг томилуулсан байна.
14. Хээрийн судалгаанд ашиглах ажлын зураг, 100x100 см-ийн тор, модон гадас, хүрз, өрөм, метр, шугам, жин, рулет, гадас, 20-30 м урттай цагаан утас, солбицлыг тодорхойлох GPS, бичиглэлийн маягт, фото аппарат, цагаан самбар, цагаан самбарын арилдаг бал, дээжний уут, хаяг, балын харандаа, царцааны тор болон бусад шаардагдах багаж хэрэгслийг бэлтгэнэ.



Зураг 1. Цагаан самбар ашиглах жишээ /зурагт цаад талбай харагдахаар байна/
Самбарт дараах мэдээллийг дэс дараалуулж бичнэ.

1. Аймгийн нэр
 2. Сумын нэр
 3. Цэгийн төрөл /бичиглэлийн, мониторингийн, дээж авсан/
 4. Цэгийн дугаар
 5. Солбицол
 6. Он сар өдөр
15. Хээрийн ажлын удирдамж, төлөвлөгөө, бэлтгэл ажлын тайланг боловсруулж захиалагчид хүргүүлж, ажил шалгасан дүгнэлт гарсаны дараа хээрийн судалгааны ажлыг эхлүүлнэ.

1.2.Нэгж талбар

Хянан баталгааны ажлыг хянан баталгааны нэгж талбарт тулгуурлаж гүйцэтгэх бөгөөд нэгж талбарыг дараах зарчмаар хуваана. Үүнд:

- Экологийн нэгж талбар (газрын гадарга, хөрс, ургамалжлын хил зааг)
- Газар ашиглалт (эрчимжсэн МАА, суурин МАА г.м)

Экологийн нэгж талбар гэсэн ойлголтонд хөрсөн бүрхэвч, ургамалжлын тархац, газрын гадарга буюу уул, хөндий, голын хөндий зэрэг газрын гадаргын хэлбэрийг харгалзана. Өөрөөр хэлбэл бэлчээрийн төрлөөр хянан баталгааны нэгж талбарыг ангилна.

Нэгж талбарын тоо нэг сумын хэмжээнд зөвхөн нутгийн ерөнхий хэмжээнээс хамаараад зогсохгүй ургамалжлын бүс бүслүүрээс ихээхэн хамаарах тул нэгж талбарын талбайг ойролцоогоор авч үзэхэд ихэнх тохиолдолд 100-4000 га хүртэл байна.

Гэхдээ 2000-4000 га талбайтай бэлчээрийн нэг төрлийн талбайн ашиглалт, хамгаалалт экологийн талаасаа харилцан адилгүй бөгөөд алаглалт гарах магадлал ихтэй. Ийм нөхцөлд хөрс, газар ашиглалтын зураг, бэлчээрийг улирлаар ашиглах хуваарийг баримтлан нарийвчлан задалж болно.

Нэгж талбарын талбайн хэмжээнээс хамааруулан мониторинг, бичиглэл, дээж авах цэгийн тоог тогтооно.

Нэгж талбар дотор, гадны нөлөөгөөр үүсч бий болсон хөрсний элэгдэл, эвдрэл, зулгаралт, газрын гадаргуугийн өөрчлөлт, бохирдолт, уурхайн овоолго, цооног болон бэлчээрийн доройтол зэрэг гадны хүчин зүйлийн нөлөөлөл, физик-геологийн үйл явц, үзэгдлийн байршлыг ажлын зурагт тэмдэглэсэн байна.

Энэ норматив баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт, арга зүйн дагуу газрын төлөв байдал, чанарын үзүүлэлтийг тодорхойлно.

Нэгж талбарын дугаарыг мэдээллийн сан болон хүснэгтэд тэмдэглэх

Мэдээллийн санд нэгж талбарыг дугаарлахдаа аймаг, сумын кодыг ашиглана.

Нэгж талбарын дугаарын эхэнд бэлчээрийг В үсгээр, тариаланг Т үсгээр, хот сууринг С үсгээр, латинаар бичнэ.

Аймаг, сумын кодыг Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код, MNS5641-0-2006 2х, MNS5641-1-2006 6х, MNS5641-2-2006 34х, MNS5641-3-2006 47х стандартад заасны дагуу тэмдэглэнэ.

Нэгж талбарын дугаар өгөх: Жишээ нь: В650100001

В-бэлчээрийн хянан баталгаа, 65-аймгийн код, 01-сумын код, 00001-нэгж талбарын дугаарыг илэрхийлнэ.

Нэгж талбар шинээр үүссэн бол өмнөх улсын хянан баталгааны дугаарыг үргэлжлүүлэн дугаарлана. Нэгж талбар хуваагдсан тохиолдолд В220100001а, В220100001б гэж тэмдэглэнэ.

Хэрэв өмнөх хянан баталгааны нэгж талбарын дугаар өөр өгөгдсөн бол түүнийг хайж олох хүснэгтийг тайланд хавсралтаар оруулна. Жишээ нь:

Хүснэгт 2

№	Газрын нэр	Өмнөх нэгж талбарын дугаар	Одоо өгч байгаа нэгж талбарын дугаар
1			

Нэгж талбарын дугаарыг зурагт тэмдэглэх

Хянан баталгааны нэгж талбарын сүлжээний зурагт нэгж талбарын дугаарыг 8/99а/2359 гэж бичнэ. Энэ нь нэгж талбарын дугаарын сүүлийн орон, бэлчээрийн индекс, талхлагдлын зэрэг, талбайн хэмжээг (га) илэрхийлнэ.

Харин нэмэлтээр өөр бэлчээрийн индекс бичигдэх тохиолдолд голлох индексийг урд нь бичнэ. Жишээ нь 31/9+214б/3339.0 г.м.

Мониторингийн цэг тэмдэглэх: M1B650100001

Нэгж талбарын дугаарын өмнө латин үсэг, тоогоор тэмдэглэнэ. М1- мониторингийн цэгийн дугаар, В-бэлчээрийн хянан баталгаа, 65-аймгийн код, 01-сумын код, 00001-нэгж талбарын дугаарыг илэрхийлнэ.

Ургамлын бичиглэлийн цэг тэмдэглэх: В1B650100001

Нэгж талбарын дугаарын өмнө латин үсэг, тоогоор тэмдэглэнэ. В1- бичиглэлийн цэгийн дугаар, В-бэлчээрийн хянан баталгаа, 65-аймгийн код, 01-сумын код, 00001-нэгж талбарын дугаарыг илэрхийлнэ.

Хөрсний дээж авсан цэг тэмдэглэх: D1B650100001

Нэгж талбарын дугаарын өмнө латин үсэг, тоогоор тэмдэглэнэ. D1- хөрсний дээж авсан цэгийн дугаар, B-бэлчээрийн хянан баталгаа, 65-аймгийн код, 01-сумын код, 00001-нэгж талбарын дугаарыг илэрхийлнэ.

1.3. Агаар, сансрын зураг ашиглах

Хянан баталгаа хийхийн өмнөх 4-5 жилийн (жил бүрийн 7-8 сард авсан, үүлгүй, 30 м-ийн нарийвчлалтай) агаар, сансрын зургийг боловсруулж, жил бүрийн ургамлын нормчилсон индекс (NDVI)-ийн зураглал хийнэ. Агаарын зураг, дрон (нисгэгчгүй нисэх төхөөрөмж)-оор авсан зураг ашигласан бол боловсруулалтыг зааврын дагуу хийсэн байна.

Жил бүрийн зургийг харьцуулан, дүгнэж, тайланд дэлгэрэнгүй тайлбарлаж оруулна.

Дээрх боловсруулалт хийсэн зургаас хөрсний элэгдэл, эвдрэл, үер усны нөлөө, элсний нүүлт зэрэг нөлөөлөлд өртсөн газрын мэдээллийг тодорхойлж, ажлын зурагт тэмдэглэж, хэрийн судалгаагаар тодруулалт хийнэ.

Агаар, сансрын зураг авсан эх сурвалж, хэрэв боловсруулалт хийсэн бол ашигласан програм, зураг боловсруулалтын арга зүйн талаар бэлтгэл, эцсийн тайланд тодорхой, дэлгэрэнгүй тусгасан байна.

1.4. Ажлын зураг

Ажлын зураг нь хянан баталгааны ажлын зураг болох төдийгүй тухайн ажил хийгдэж дуустал эх материал болж ашиглагдана.

Урьд өмнө хийгдсэн судалгааны материал, баримт бичиг, статистикийн тоо баримт, газрын нэгдмэл сангийн тооллого, газрын улсын бүртгэлийн мэдээлэл, өмнө хийгдсэн хянан баталгааны материал, өвөлжөө, хаваржааны байршлын зураг, 1:100000 масштабтай хөрс, ургамалжлын зураг, агаар, сансрын зураг, хянан баталгаа хийхээс өмнөх 4-5 жилийн ургамлын нормчилсон индекс (NDVI)-ийн зураг ашиглан, 1:100000 масштабтай байр зүйн зурагт тулгуурлан ажлын зураг бэлтгэнэ. Өөрөөр хэлбэл байгаль, цаг уур, хөрс, ургамалжил, бэлчээр тэжээл, газар ашиглалт, агаар сансрын зураг, өмнө хийгдсэн зурган болон тоон мэдээллийг ашиглан ажлын зураг бэлтгэнэ. Ажлын зурагт дараах тоон мэдээлэл суурь байдлаар ашиглагдах бол зарим мэдээллийг ажлын зурагт шинээр тэмдэглэнэ. Жишээ нь:

1. Хянан баталгаа хийгдэж байгаа аймаг, сумдын хилийн цэс, өмнө хийгдсэн хянан баталгааны нэгж талбарын сүлжээний зургийг тоон хэлбэрээр,
2. 1:100000 масштабын хөрс, ургамалжлын болон бэлчээр тэжээлийн, газрын нэгдмэл сангийн зургийг тоон хэлбэрээр,
3. 1:100000 масштабын байр зүйн тоон зургийг тоон хэлбэрээр газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын архиваас авч ашиглана.
4. Өмнөх хянан баталгааны ажлаар тогтоосон бичиглэл хийсэн, дээж авсан цэгийг ажлын зурагт тэмдэглэнэ.
5. Шинээр байгуулах мониторингийн, бичиглэлийн, дээж авах цэгийн байршлыг ажлын зурагт тэмдэглэнэ.

6. Тухайн сумын өвөл-хаврын, зун-намрын бэлчээрийн хуваарь, түүний байршлыг ажлын зурагт тэмдэглэнэ.

1.5.Мониторингийн цэг

Бэлчээрийн хянан баталгааны ажилд мониторингийн цэгээс гадна талбар гэсэн ойлголт байх ба энэ нь 100*100 м² хэмжээтэй байна. Энэ талбарт мониторингийн цэг байрлана. Талбарын 4 өнцгийн солбицолыг геоботаникийн бичиглэлийн маягтад тэмдэглэнэ.

Мониторингийн цэг нь дараах шаардлагыг хангасан газарт байрлана. Үүнд:

1. Бэлчээрийн төрөл тус бүрээр
2. Томоохон уул уурхайн ашиглалт бүхий газраас 10 км зайд /шууд харагдахаар, салхин доор газарт/

Харин бичиглэлийн цэгийг өөрчлөлтөд орсон болон мониторингийн цэг бүхий нэгж талбарт тогтоох ба солбицолыг зурагт тэмдэглэх бөгөөд газар дээр солбицолыг тодорхойлсон байна.

Мониторингийн цэгт газар дээр нь дараах 2 судалгааг хийнэ.

1.Хөрсний судалгаа:

1. Хөрсний зүсэлт хийх
2. Хөрсний механик бүрэлдэхүүн үзэх /хээрийн нөхцөлд
3. Ялзмагт үеийн зузаан тодорхойлох
4. Ургамлын үндэсний тархалт
5. Хөрсний дээж авах (энгийн дээж авах)
6. Хөрсний бичиглэл хийх
7. Фото зураг авах (цагаан самбар ашиглах)

Хөрсний өнгөн хэсгээс дээж авахад “Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS3298-1990” стандартыг мөрдөнө. Харин хөрсний зүсэлтээс дээж авахад энэ стандарт тохирохгүй.

2.Ургамлын судалгаа:

1. Ургамлын зүйлийн бүрэлдэхүүн (3-5 давталт)
2. Ургамлын тусгаг бүрхэц (3-5 давталт)
3. Ургац (өндөр уулын хээр, уулын хээр, хээр, цөлийн хээрийн өвслөг ургамалтай бэлчээрт 1м- сорьцын талбайгаас 5 давталттай, нугын бэлчээрээс 0.5м х 0.5 м хэмжээтэй сорьцын талбайгаас 5 давталттай)
4. Фото зураг авах (цагаан самбар ашиглах)

Хөрсний бүтэн зүсэлт хийх шаардлагатай эсэхийг хөрсний судалгааны материал, бэлтгэл, хээрийн ажлын явцад тогтооно. Хөрсний зүсэлтийг Z-1, малталтыг M-1 гэж дугаарлана.

Харин геоботаникийн бичиглэл хийсэн цэгээс хөрсний дээж авах эсэх нь тухайн ажлын онцлог, газрын нөхцөл байдлаас хамаарна.

Хөрсний дээж хаягтай байх бөгөөд дараах мэдээллийг балын харандаагаар бичиж, уутнаас бэхэлнэ. Хөрсний хаягийг хөрсний дээж хийсэн уутанд хийж болохгүй.

- Дээжний дугаар
- Аймаг, сумын нэр.....
- Солбицол
- Хянан баталгааны нэгж талбарын дугаар
- Дээж авсан гүн, см
- Огноо
- Дээж авсан хүний нэр

Хөрсний дээжнүүдийг холилдуулахгүй байхад анхаарч тээвэрлэнэ.

Фото зураг авахдаа ойр орших уул болон онцлох тэмдэг бүхий газрыг фон болгох эсвэл цагаан самбар ашиглаж болох бөгөөд үүнийг хөрсний бичиглэлийн маягт, мониторингийн хувийн хэрэгт ашиглана. Мөн эцсийн тайланг бичихдээ СД-д тоон хэлбэрээр хуулбарлаж ирүүлнэ.

Мониторингийн цэгийн дугаарыг энэ зааврын 1.2-т заасны дагуу дугаарлаж, цэг бүрээр хувийн хэргийг бүрдүүлнэ. Үүнд:

1. Хувийн хэргийн нүүр хуудсанд "... аймгийн сумын бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны мониторингийн сүлжээний дугаартай цэгийн хувийн хэрэг, ... он" гэсэн загвартай байна.
2. Мониторингийн цэгийн газрын гадаргын болон байршлын ерөнхий мэдээлэл
3. Мониторингийн цэгийн хөрсний бичиглэл
4. Мониторингийн цэгийн геоботаникийн бичиглэл
5. Мониторингийн цэгийн хянан баталгааны дүгнэлт буюу паспорт
6. Өмнө хийсэн хянан баталгааны үр дүнтэй харьцуулсан дүн шинжилгээ, дүгнэлт

1.6.Бичиглэлийн цэг

Бичиглэлийг дараах 2 тохиолдолд хийх бөгөөд энэ аргачилсан зааврын 1.2-т заасны дагуу дугаарлана.

1. Мониторингийн цэгийн хөрс, ургамалжлын мэдээллийг баталгаажуулах зорилгоор хийнэ.
2. Маршрут судалгааны явцад нэмэлт хэмжилт хийх шаардлагатай бол хийнэ.

1.7.Бэлтгэл ажлын тайлангийн агуулга

- **Нүүр хуудас** нь хүрээтэй байх ба дотор нүүр хуудсанд хянан баталгаа гүйцэтгэсэн аж ахуйн нэгжийн гүйцэтгэсэн ажилтнууд, захирал гарын үсэг зурж баталгаажуулан, тамга дарсан байна. (ЗАХИАЛАГЧИЙН НЭР /үсгийн хэмжээ 12, томоор/, АЖЛЫН НЭР /үсгийн хэмжээ 16, томоор/, ГҮЙЦЭТГЭГЧИЙН НЭР /үсгийн хэмжээ 14, томоор/, УЛААНБААТАР, ...ОН /үсгийн хэмжээ 12, томоор/)
- Гарчиг (хуудасны дугаартай байх)
- **Ерөнхий мэдээлэл** (ажлын зорилго, зорилт, гэрээний дугаар, хугацаа, гүйцэтгэгчийн нэр, тусгай зөвшөөрлийн талаарх товч мэдээлэл, баримталсан эрх

зүйн баримт бичгийн нэр /жагсаалт, баталсан эрх бүхий этгээдийн нэр/ /хуулийн заалтуудыг нэг бүрчлэн бичихгүй/, урьд нь тухайн хянан баталгааг гүйцэтгэсэн талаарх мэдээлэл, гүйцэтгэх ажлын хүрээнд хийхээр төлөвлөсөн ажлын жагсаалт, хугацаа, биелэлт, цуглуулсан материалын жагсаалт, судалгаа хийсэн болон дүн шинжилгээ хийсэн арга г.м)

- **Ажлын зураг боловсруулсан тухай** (агаар, сансрын зураг боловсруулалтын тухай буюу хиймэл дагуулын нэр, танилцуулга, авсан эх сурвалж, дугаар, нийт сцений /цуваа/ тоо, нарийвчлал, файлын хэмжээ, зураг ашиглан тодруулалт хийсэн болон NDVI зураглал хийсэн арга зүй, ажлын зураг боловсруулахад хэрэглэсэн зураг мэдээллийн жагсаалт, эх сурвалж, он, зөрүүтэй байдлыг зассан тухай тайлбар, үндэслэл, өмнөх хянан баталгааны зургийн тусгагт шилжүүлсэн эсэх, ажлын зургийн үндсэн тусгаг, боловсруулалт хийсэн програм, ажлын зурагт тэмдэглэсэн цэгийн төрөл, солбицолын жагсаалт, үндэслэл, эх сурвалж, он, хээрийн судалгааны маршрут, дроноор авсан зураг ашигласан бол зургийн талаарх мэдээлэл г.м)
- **Байгаль, нутаг дэвсгэрийн ерөнхий нөхцлийн мэдээлэлд** (хянан баталгаа хийгдэж байгаа газрын газар зүйн байршил, газрын гадарга, уур амьсгал, хөрсөн бүрхэвч, ургамалжлын мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийж, тайлбарлан бичнэ. Мөн холбогдох зурган мэдээллийг оруулна. Газар ашиглалтын тухай статистик мэдээ, ялангуяа малчин өрхийн тоо, малын тооны өсөлт, газрын нэгдмэл сангийн тайлан, мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийж, газрын гадаргын өндөржилт, цаг уур, хөрс, ургамлын зураг зэргийг оруулсан байна. Энэ бүлгийг эцсийн тайланд ашиглах тул эх сурвалж, оныг заавал дурьдах, үүнийг ашигласан материалын жагсаалтад цагаан толгойн дарааллаар оруулсан байна)
- **Хээрийн судалгааны төлөвлөгөө** (оролцох мэргэжилтэн, албан тушаалтан, ажилтны нэр, гүйцэтгэх үүрэг, хугацаа зэргийг хүснэгтээр харуулна. Хээрийн судалгааны маршрут, явах км, урьдчилан тогтоосон бичиглэл, мониторингийн цэгийн тоо, байршил зэргийг зургаар харуулна. Хээрийн судалгаанд ашиглах техник, багаж хэрэгслийн жагсаалт, лаборатори болон бусад чиглэлээр хамтран ажиллах гэрээний хуулбар, тэдгээр байгууллагын хийх ажлын жагсаалт, шинжилгээний арга, хийх хугацаа, үнэ өртөг, магадлан итгэмжлэгдсэн эсэх, лабораторийн товч түүх г.м)
- **Ашигласан материалын жагсаалт:** Хууль, журам, норм, дүрэм, зааврыг эхэнд оруулах ба зохиогч, байгууллагын бүтээлийг тус тусад нь цагаан толгойн үсгийн дарааллаар жагсааж бичнэ. Жагсаалт үйлдэхдээ зохиогчийн нэр, овгийн үсэг, зохиолын нэр, хэвлэсэн газар, он, баталсан байгууллагын нэр зэрэг дарааллаар бичнэ.
- **Хавсралт:** (орон нутгийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлсэн албан бичиг, хамтран ажиллах гэрээний хуулбар г.м)
- **Баталгааны хуудас**

(Архивын шаардлага: Тайлан засваргүй гэж үзсэн бол нүүрэн талд 2 хуудас хүснэгт оруулж, тайлангийн хуудас бүрийг дугаарлаж, архивын (бор) хавтсаар хавтаслаж, үдсэн (цагаан утас) байна)

1.8.Бэлтгэл ажлын захиалагчийн хяналт

Бэлтгэл ажлын тайланг 2 хувь хэвлэж, захиалагчид албан бичгийн хамт ирүүлэх бөгөөд газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хариуцсан хэлтсийн хөдөө аж ахуйн газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хариуцсан мэргэжилтэн тайланг дараах дарааллын дагуу шалгана. Үүнд:

1. Тайланг аргачилсан зааварт заасан агуулгаар бичигдсэн эсэх (дэд гарчиг бүрт заасан санааг оруулсан байдал)
2. Найруулгын болон үсгийн алдаа байгаа эсэх
3. Эх сурвалжийг дурьдсан эсэх (Эх сурвалж /ном, сэтгүүл, иш татсан материал/ ашигласан тохиолдолд нэр, хуудасны дугаар бичсэн байна.)
4. Зураг, хүснэгтийн нэр, масштаб, таних тэмдэг ашиглалт
5. Байгаль нутаг дэвсгэрийн ерөнхий мэдээлэл ойлгомжтой бичигдсэн байдал

Хэрэв тайлан шаардлагыг хангаагүй, бэлтгэл үе шатант хийх ажил хангалтгүй бол ажил шалгасан акт гарахгүй байх, хээрийн судалгаанд гаргахгүй байх үндэслэл болно.

ХОЁР.ХЭЭРИЙН СУДАЛГАА

Хээрийн судалгаа нь хянан баталгааны ажлын гол хэсэг бөгөөд үүнээс ажлын гол үр дүн хамаарна.

Хээрийн судалгаа нь ярилцлагын судалгаа, ургамлын судалгаа, хөрсний судалгаа, цэг тогтоох, захиалагчийн хяналт гэсэн хэсгээс бүрдэнэ.

Энэ ажилд орон нутгийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тухайн асуудлыг хариуцсан мэргэжилтэн, сумын газрын даамал заавал оролцоно. Энэ нь хээрийн судалгаанд орон нутгийн төлөөллийг оролцуулах, хээрийн судалгааг газар дээр нь хэрхэн хийж байгаатай танилцах, суралцах, захиалагчийн хяналтын үүргийг давхар гүйцэтгэх боломж бүрдэнэ.

2.1.Ярилцлагын судалгаа

Ярилцлагын судалгааг дараах байдлаар явуулна.

1. Хээрийн судалгааны ажлыг эхлэхийн өмнө орон нутгийн удирдлага, аймгийн байгаль орчин, хөдөө аж ахуйн болон газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын удирдлага, мэргэжилтэн, сумын газрын даамал нарт гүйцэтгэгч хянан баталгааны ажлын зорилго, чиглэл, ач холбогдол, хээрийн судалгаа хийх газрууд, хийгдэх ажлыг дэлгэрэнгүй танилцуулна.
2. Нөгөө талаар энэ уулзалтаар сум, орон нутгийн бэлчээрийн өөрчлөлтийн талаар санал солилцож, аймаг, орон нутгаас авч хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээ, сүүлийн жилүүдэд доройтсон, бэлчээр хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан байдал, газруудыг тодорхойлох, өвөлжөө хаваржааны болон малын тооны өсөлт, бууралт, бэлчээр усжуулалт, худаг усны хүрэлцээ, малчдын бүлэг, тэдгээрийн бэлчээр ашиглалтын байдал, улирлын хуваарь, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний нэг хэсэг болох бэлчээр зохион байгуулалтын төлөвлөгөөний сүүлийн 5 жилийн хэрэгжилт,

малын гоц халдварт өвчин гарсан голомт, байршил, тархац, үлий цагаан оготоны тархалт, уул уурхайн (ашиглалтын болон хайгуулын) нөлөө, хүнд металлын болон химийн бохирдол, эдгээрийн шалтгаан нөхцөл, үр дүн, гарсан зардлын талаар нарийвчлан тэмдэглэж, ажлын зурагт тэмдэглэнэ.

3. Бэлтгэл үе шатанд тогтоосон хээрийн судалгааны маршрутыг хэлэлцэж, орон нутгийнханы саналыг харгалзан судалгаа хийх нэмэлт газруудыг тодорхойлж, ажлын зурагт тэмдэглэж, судалгааны маршрутыг тодотгоно.
4. Орон нутгийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын архивт болон сумын газрын даамалд байгаа бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын улсын болон захиалгат хянан баталгаатай холбоотой акт, баримт бичгийн бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалт, ашиглалтын талаар дүгнэлт хийж, хээрийн ажлын тайланд тусгасан байна.

Ярилцлагын арга нь сумын удирдлага, малчдын оролцоог хангах, хээрийн судалгааны маршрутыг тодотгох, шаардлагатай газруудын мэдээлийг нарийвчлах, хээрийн ажлын маршрут, хугацааг хэмнэх зэрэг олон давуу талтай тул зайлшгүй хийх шаардлагатай.

2.2. Хянан баталгааны үзүүлэлтийг тодорхойлох

Хянан баталгааны үзүүлэлт

Хүснэгт 3

№	Үндсэн үзүүлэлт	Дэд үзүүлэлт	Тодорхойлох арга
1	Бэлчээрийн доройтол (сул, дунд, хүчтэй)	Ургамлын зүйлийн зүйлийн арви (эвсэл үүсгэгч, хөнөөлтэй, хортой ургамал)	Друдегийн арга
		Ургамлын зүйлийн тусгаг бүрхэц (эвсэл үүсгэгч, хөнөөлтэй, хортой ургамал,)	Л.Г.Раменскийн арга
		га-ийн ургац	Жигнэх
2	Бэлчээрийн газрын гадаргын төрх байдлын өөрчлөлт	Хөрсний элэгдэл	Бэлчээрийн газрын хөрсний элэгдэл эвдрэл, ургамлын талхлагдлыг тогтоох ерөнхий шаардлага. MNS 5546:2005
		Хөрсний эвдрэл	
		Элс нүүлт	
		Хортон мэргэгчдийн хөнөөлд нэрвэгдсэн байдал, тархац, хил зааг	
		Хортон шавьжийн хор хөнөөлд нэрвэгдсэн байдал, тархац, хил зааг	
3	Бэлчээрийн газрын гадаргын ба хөрсний бохирдол	Малын халдварт өвчин гарсан газрын байршил	Хөрсний дээжинд лабораторын шинжилгээ хийх
		Хөрсөн дэх хүнд металлын бохирдол	

Хянан баталгааны үзүүлэлтийг тодорхойлохдоо дараах зүйлийг анхаарах шаардлагатай. Үүнд:

1. Хянан баталгааны нэгж талбарын хэмжээ 1000 хүртэл га талбайтай бол 3, 1000-аас дээш га талбайтай бол 4 давталттайгаар хянан баталгааны үзүүлэлтийг тодорхойлно.

2. Хэрэв газрын төлөв байдал, чанарт нөлөөлөхүйц байгаль, газар зүй, ашиглалт, хамгаалалтын ялгаа байгаа тохиолдолд зонхилох хэв шинжит бэлчээрт хэмжилт хийнэ.
3. Нэгж талбарын дотор хэв шинжийн бус хэсэг нийт талбайн 20 хувиас бага тохиолдолд тэр хэсэгт нэмэлт хэмжилт хийхгүй, зөвхөн тусгай тэмдэглэл хийх бол 20 хувиас их тохиолдолд хянан баталгааны нэгж талбарыг хувааж, хэмжилтийн тоог нэмэгдүүлнэ.
4. Хэмжилтийн үзүүлэлтүүд жигд бус, хэмжилт хийх цэгийн сонголттой холбоотой ялгаа гарсан тохиолдолд давталтын тоон дундажийг бүрэн тодорхойлох хэмжээнд нэмэгдүүлнэ.
5. Газар ашиглалтын зориулалтаас үл хамаарч хянан баталгааны нэг төрлийн ажиглалт хэмжилт, задлан шинжилгээнд хэрэглэх арга нэг стандартынх байна.
6. Хэмжилт, задлан шинжилгээний нэг давталтын үзүүлэлт бусад давталтынхаас эргэлзээ төрүүлэхүйц зөрүүтэй гарах тохиолдол байдаг. Ийм нөхцөлд тухайн давталтын тоон үзүүлэлтийг арифметикийн дундажид оруулна.
7. Б.А.Доспеховын сурах бичигт арифметик дундажийн эргэлзээтэй үзүүлэлтийг гишүүнээр авах, эсэх тухай шалгуурыг ашиглан, таамаглалыг шалгана. Өөрөөр хэлбэл ажиглалт, задлан шинжилгээний аливаа үзүүлэлтийг шинжээчийн санаагаар дүгнэлтээс хасах эсвэл эргэлзээтэй байснаар санал нийлэхгүй бусадтай адилтган үзэж болохгүй.

2.3. Бэлчээрийн доройтол

Бэлчээрийн доройтолыг дараах дэд үзүүлэлтээр тодорхойлно. Үүнд:

1. ургамлын зүйлийн бүрэлдэхүүний өөрчлөлт, ш
2. ургамлын тусгац бүрхэцийн байдал, %
3. ургац хэмжээ, цн/га

Ургамлын зүйлийн бүрэлдэхүүний өөрчлөлтийг Друдегийн аргаар, ургамлын тусгац бүрхэвчийг Л.Г.Раменскийн аргаар тус тус тодорхойлох бөгөөд газар дээр нь тодорхойлж, ургамлын бичиглэлийн маягтад бичнэ. Фото зургаар баталгаажуулах шаардлагатай.

Ургамлын зүйлийн бүрэлдэхүүн тодорхойлох явцад эмийн болон нэн ховор ургамал, хорт ургамлын тархалтыг тодорхойлно.

Хэрэв дээрх аргаас өөр аргаар тодорхойлох бол хуучин ба шинэ аргын ялгааны онцлогт тохируулан үзүүлэлтийг нэгээс нөгөөд шилжүүлэх, харьцуулах коэффициентийг заавал тодорхойлох шаардлагатай. Энэ үндсэн дээр харилцан адилгүй үзүүлэлтүүдийг өөр хооронд нь харьцуулан үнэлэлт, дүгнэлт өгөх боломжтой.

Бэлчээрийн доройтолыг 3 ангилах бөгөөд бэлчээрийн газрын хөрсний элэгдэл эвдрэл, ургамлын талхлагдлыг тогтоох ерөнхий шаардлага. MNS 5546:2005 стандартад заасны дагуу тодорхойлж, зураглана.

1. Бага

2. Дунд
3. Хүчтэй

Бага доройтсон бэлчээр:

Үндсэн бүлгэмдлийн зонхилогч, дэд зонхилогчийн бүлгэмдэл үүсгэх үүрэг өөрчлөгдөөгүй. Бага зэрэг доройтсон бол бэлчээрийн зүйлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт бага зэрэг орж, шэвсэл үүсгэгч ургамлын арви буурч, алаг өвсний арви ихсэх хандлагатай.

Дунд зэрэг доройтсон бэлчээр:

Зонхилогч, эвсэл үүсгэгч ургамлын арви багаснаДунд зэрэг доройтсон бол зүйлийн бүрэлдэхүүний тоо мэдэгдэхүйц цөөрч, эвсэл үүсгэгчийн бүрхэц эрс буурч, бүрхэцэд талхлагдлын заагуур ургамлын арви ихэснэ.

Хүчтэй доройтсон бэлчээр:

Эвсэл үүсгэгч ургамлын арви эрс буурч ганц нэг болон сийрэгжиж, харин мал иддэггүй болон бэлчээрийн хог ургамлын арви нэмэгдэнэ. Хүчтэй доройтсон бол эвсэл үүсгэгч нь бүрмөсөн өөрчлөгдөж, зүйлийн тоо цөөрч, тухайн бэлчээрт доройтлын заагуур ургамал зонхилно.

Ургамлын тусгац бүрхэцийг тодорхойлох явцад нийт бүрхэцэд доройтлын заагуур ургамлууд дангаараа давамгайлан тархаж байгаа эсэхийг нягтлан геоботаникийн бичиглэлд тэмдэглэнэ.

2.3.1. Ургамлын зүйлийн бүрэлдэхүүн тодорхойлох

Бэлчээрийн ургамалжил нь уулын ойт хээрийн бүслүүр болон бус бусын ургамалжил болох уулын нуга, голын хөндийн нуга, нам хотос нь олон зүйлээс бүрдэх ба хээр, цөлийн хээр, цөлийн бүсэд цөөн зүйл ургамлаас бүрддэг. Мөн ургац нь бага боловч олон зүйл ургамлаас бүрдсэн эвсэл ургац ихтэй боловч зүйлийн бүрэлдэхүүн ядмаг байж болно.

Ургамлын зүйлийн бүрэлдэхүүнийг хамгийн бага талбайн аргаар, ургамлын зүйлийн арвийн өөрчлөлтийг Друдегийн аргаар тодорхойлно.

100 (10*10) м² талбайн 4 өнцөгт тэмдэг тавьж, нэг өнцгөөс нөгөө өнцгийг чиглэн диогналиар явж тохиолдох бүх ургамлыг зүйлээр ургамлын бичиглэлийн хүснэгтэд бичиж, эргэж талбайгаараа нэлэнхүйд явж хаягдсан ургамал байгаа эсэхийг шалгана.

Зүйлийн жагсаалт хийх үед танихгүй юмуу эргэлзээтэй ургамал тааралдвал цуглуулганд авч, фото зураг авах, дугаар, болзолт нэр, хугацаа, ургамал цуглуулсан газар ба бэлчээрийн хэв шинжийг цаасан дээр бичиж хавсаргаж, тайланд дэлгэрэнгүй бичнэ.

Ургамлын зүйлийн бүрэлдэхүүнийг дараах давталтаар үзнэ.

- 500 хүртэл га-д 2,
- 500-1000 хүртэл га-д 3,
- 1000 га түүнээс дээш талбайд 4-өөс доошгүй

Ургамлын бичиглэлийн хүснэгт

Хүснэгт 4

№	Зүйлийн нэр	Арви, балл	Өндөр, см	Хөгжлийн үе шат	Тайлбар
1.	Монгол/латин нэр				
2.					
3.					
4.					
5.					
6.					

Бэлтгэл ажлын хүрээнд холбогдох байгууллагуудаас тэжээлийн ач холбогдолтой ургамал, хөнөөлтэй, хортой, нэн ховор, ховор ургамал байгаа эсэхийг урьдчилан ажлын зурагт тэмдэглэсэн байна. Хээрийн судалгааны явцад эдгээр ургамлын зүйлийн бүрэлдэхүүн, арви, бүрхэцийн талаар мэдээлэл цуглуулахад анхаарч, байршил, солбицлолыг зурагт тэмдэглэнэ.

Хэрэв

2.3.2. Ургамлын тусгац бүрхэцийг тодорхойлох

Ургамлын тусгац бүрхэвчийг (Газрын тухай хуульд бичигдсэнээр) мэргэжлийн хэллэгээр "Ургамлын ерөнхий бүрхэвч" гэж нэрлэдэг.

Ургамлын тусгац бүрхэц нь газрын хэдэн хувь ургамлаар буюу иш, навч, цэцэг зэргээр хучигдсаныг хувиар илэрхийлэх бөгөөд 1 м² тор ашиглан тодорхойлно.

Хэмжилт хийхдээ торыг газар тавьж, эгц дээрээс нь харж, торны 1 нүдийг 1 хувь гэж тооцон ургамлын бүрхэцийг нүд бүрээр тоолон, ургамлын бүрхэц, халцгай газрын хэмжээ, хад чулууны хэмжээ, хагдны бүрхэцийг тус тус хувиар гаргана.

Энэ хэмжилтийг 3-5 давталттай хийж дараах хүснэгтээр тооцоо хийнэ.

Ургамлын тусгац бүрхэц тодорхойлох хүснэгт

Хүснэгт 5

№	Ургамлын нэр	Давталтын тоо					Дундаж, %
		1	2	3	4	5	
1	Ургамлын нийт бүрхэц						
	Үүнээс олшрогч ургамлын бүрхэц						
2	Хагд						
3	Хал чулуу						
4	Халцгай газар						

Нийт бүрхэцэд талхлагдлын заагуур ургамлууд дангаараа давамгайлан тархаж байгаа эсэхийг нягтлан ургамлын бичиглэлийн маягтад тэмдэглэнэ.

Харьцуулах үндсэн мэдээлэлд аль аргыг хэрэглэснээс хамаарч, ургамал тус бүрийн арвийг хүснэгт 5 болон 6-г ашиглан дүйцүүлэх хувийг өгнө.

Браун Бланкийн үнэлгээ

Хүснэгт 5

Ургамлын тусгац бүрхэц, хувь	Оноо
Ганц нэг	Un
1-3	+
3-5	Eg
5-10	1
10-25	2
25-50	3
50-75	4
75-100	5

Энэ үнэлгээний баллын алхам хол тул бусад аргатай харьцуулахад алдаа бага, зарцуулах хугацаа богино байна.

Ургамлын тусгац бүрхэвч нэг шатлалаас нөгөөд шилжихдээ өөрчлөлт орсон гэсэн ерөнхий дүгнэлт хийх ёстой. Гэхдээ улирлын ба цаг агаарын, хэмжилтийн алдааг харгалзах шаардлагатай бөгөөд үүнийг баримттайгаар тайланд тусгана.

Друдегийн үнэлгээ

Хүснэгт 6

Бүрхэцийн хэмжээ		Зүйлийн баялгийн онцлог	Хоорондын зай, см
Балл	Хувь		
Cor ²⁻³	25<	Нэн арвин	<20
Cor ¹	10-25	Олон	20-40
Sp	5-10	Цөөн/тармаг	40-100
Sol	1-5	ганц нэг	100-150
R	1>	Нэн ховор	<150

Ургамлын зүйлийн бүрэлдэхүүний нэг шатлалаас нөгөөд шилжсэн тохиолдолд өөрчлөлт гарсан гэж дүгнэнэ. Гэхдээ арифметикийн дундажийг бүрдүүлэгч нэгж үзүүлэлтүүд савалгаа ихтэй, мөн дундаж үзүүлэлт хоёрын шатлалын зааг орчимд байх тохиолдолд дундажийн алдааг тодорхойлох зайлшгүй шаардлагатай. Өөрөөр хэлбэл өөрчлөлтөд үнэлэлт өгөхдөө уян хатан байна.

2.3.3. Ургац тодорхойлох

Бэлчээрийн ургацыг тодорхойлохдоо 1м² талбайн ургамлыг газрын гадаргаас 0 см-ийн өндөрт хайчилж, агаарын хуурай масс тодорхойлно.

Сөөгт бэлчээрийн ургацыг тодорхойлохдоо тодорхой талбайн сөөгийг зүйл тус бүрээр, том жижиг хэмжээгээр ангилан тоолно. Үүний дараа ангилсан бут тус бүрээс

5 ширхэгийг сонгон, зөвхөн нэг наст ногоон мөчрийг түүвэрлэн авч, жинлэн талбайд шилжүүлэн тооцно.

Ургацын дундаж хэмжээг доорх хүснэгтийн дагуу тодорхойлох бөгөөд ц/га нэгжээр илэрхийлнэ.

Ургац тодорхойлох

Хүснэгт 7

№	Газрын нэр	Хэвшлийн нэр	Хуурай жин, гр /Давталт/					Дундаж ургац, ц/га 95.5 гр /10 9.5 цн/га
			1	2	3	4	5	
1			65.8	112.5	89.5	112.0	98.0	

Бэлчээрийн даацын тооцоог бэлчээрийн биологийн ургац бус зөвхөн малд идэгдэх бодит ургацад тулгуурлан хийх бөгөөд биологийн ургацыг дараахь итгэлцүүр ашиглан бодит ургацад шилжүүлнэ.

Зуны бэлчээрийн биологийн ургацыг сарын дунджид шилжүүлэх итгэлцүүр

Ургамалжлын бүс, бүслүүр		Засварын итгэлцүүр (сараар)			
		5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар
Уулын ойт хээрийн бүслүүр	Уулын хээр	0.11	0.41	0.81	1.0
	Нуга	0.13	0.37	0.77	1.0
Хээрийн бүс		0.10	0.37	0.77	1.0
Цөлийн хээрийн бүс		0.17	0.32	0.59	1.0

Бэлчээрийн зуны дээд биологийн ургацыг улирал, сарын ургацад шилжүүлэн тооцох итгэлцүүр

Ургамалжлын бүслүүр, бүс	Зуны дээд ургац	Зун	Намар	Өвөл	Хавар	Зун, намар	Өвөл, хавар
Уулын хээрийн дэд бүслүүр	1.0	0.59	0.85	0.70	0.53	0.72	0.62
Уулын нуга	1.0	0.54	0.81	0.57	0.48	0.67	0.52
Хээрийн бүс	1.0	0.59	0.83	0.60	0.45	0.71	0.52
Цөлийн хээрийн бүс	1.0	0.50	0.92	0.65	0.33	0.66	0.48

Ийнхүү тооцсон биологийн ургацаас ургамалжлын бүс бүслүүр, улирлыг харгалзан бодит ургацыг тооцно.

Бэлчээрийн биологийн ургацыг бодит ургацад шилжүүлэн тооцох ашиглалтын итгэлцүүр

№	Ургамалжлын бүс, бүслүүр	Улирал	
		Зун-намар	Өвөл-хавар
1.	Өндөр уулын бүслүүр	50-60%	55-65%
2.	Уулын ойт хээрийн бүслүүр	50-60%	55-65%
3.	Хээрийн бүс	60-65%	65-70%
4.	Цөлийн хээр, цөлийн бүс	65-70%	65-70%

2.4. Бэлчээрийн газрын гадаргын төрх байдлын өөрчлөлт

Гадаргын төрх байдлын өөрчлөлт гэдэгт хүний болон байгалийн хүчин зүйлийн нөлөөгөөр томоохон хэмжээний овоолго, нүхийг хамруулна. Эдгээр талбайг нэг бүрчлэн зурагт тусгасан байх ба зургийн масштабаас хамаарч цэг болон талбайгаар дүрслэх эсэхийг гүйцэтгэгч шийдвэрлэнэ.

Гадаргын төрх байдлын өөрчлөлтөд орсон газрын талаар шалтгаан, нөхцлийг тайланд дэлгэрэнгүй тайлбарласан байна.

Жишээлбэл, геологи, уул уурхайн чиглэлээр зам гүүр, барилгын материал олборлох, батлан хамгаалах зорилгоор бий болж хаягдсан овоолго, нүх, худгийн хүрээ, хөрсний намагшилт, давсжилт, элсний нүүлт зэрэг гадаргын өөрчлөлт орно.

Харин айлын буурь, морь, ботгоны уяа, тарваганы дош, овоо чулуу зэрэг микро ба мезо өөрчлөлтийг оруулах шаардлагагүй.

Хүний үйл ажиллагаатай тэр бүр хамаатай биш ч гэсэн бэлчээрийн талбайн шал, шавар үүсэх сөрөг процесс нилээд хэмжээгээр байдаг бөгөөд удаан хугацаанд үүсдэг тул шинээр бий болсон газруудыг зурагт дүрсэлсэн байна. Гэхдээ жижиг ч гэсэн шал, намаг, өрх зэрэг нь хянан баталгааны биеэ даасан талбар болно.

Газар ашиглалтад нөлөөлөх сайжруулалттай холбоотой гадаргын өөрчлөлт, бэлчээрийн газарт том талбай эзлэх бөгөөд жижиг талбайг цэг хэлбэрээр тэмдэглэнэ.

Харин ажлыг хөнгөлөх үүднээс бэлчээр газрын гадаргын өөрчлөлтийг зөвхөн актанд тэмдэглэх хүрээнд хязгаарлаж болно.

Бэлчээрийг төрх байдлаар нь сөөгтэй, довонтой, чулуутай, цэвэр гэж нь ангилан тархалтаар нь зэрэглэлд хуваана.

1. 5-15% тархалттай бол бага
2. 16-30% тархалттай бол дунд
3. 31% дээш тархалттай бол их

2.4.1.Бэлчээрийн хөрсний элэгдэл, эвдрэл

Энэ үзүүлэлтийг “Бэлчээрийн газрын хөрсний элэгдэл эвдрэл, ургамлын талхлагдлыг тогтоох ерөнхий шаардлага MNS 5546:2005” стандартын дагуу тодорхойлно.

Хөрсний элэгдэл эвдрэлд гуу жалга, хуурай сайр, ховил, элсэн дов, хайрга, чулуун хучлага орно. Мөн хөрс нь зулгарч усаар эвдэгдсэн ба салхиар хийссэн нутаг их хэмжээгээр тохиолдоно.

Бэлчээрт хөрсний шугаман эвдрэл элбэг бөгөөд ажлын зурагт байршлыг тэмдэглэж, урт, өргөн, гүнийг зураг, тайланд тодорхой тусгана.

Харин хөрс усаар нэлэнхүйдээ угаагдах, салхиар хийсэх процессын эзлэх талбай ихээхэн цар хүрээтэй бөгөөд бэлчээрийн талхлагдалтай хил давхцаж гардаг болохыг анхаарах хэрэгтэй.

Хөрсний эдгээр нэлэнхүй элэгдэл, эвдрэл нь юуны өмнө элсний хуралт, хайрга, элсэн хучлага, хөрсний үржил шимт үе давхаргын нимгэрэлт зэргээр илэрнэ. Бэлчээрт элсний хуралт, хайрган хучлага алаглаж үүсдэг тохиолдол их бий. Иймээс ялангуяа элс хурсан талбайн хүрээ, эзлэх хувь, хурсан хэлбэр, хурдасны зузаан зэргийг хэмжиж тэмдэглэнэ. Энд мөн гол горхи, хуурай сайрын хөл адгаар үүссэн төрөл бүрийн хурдаст ялангуяа чулуу, наанги шороонд дарагдсан талбай багтана.

Бэлчээрийн хөрсний салхины элэгдэл мөн бутанд улайлж тогтсон элсний хэлбэрээр илэрдэг болохыг анхаарах хэрэгтэй.

Техникийн гаралтай хөрсний элэгдэл, эвдрэлд авто зам, малын зөрөг, хот айлын зуслангийн буйр зэрэг орох бөгөөд тэдгээрийг ажлын зурагт тэмдэглэж, солбицолыг тодорхойлно.

Сүүлийн жилүүдэд бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор шинээр барих автозамын далангийн шороо авсан карьер, уурхайн ашиглалттай холбоотой автомашинаас үүссэн зам, түүний тоосжилтын хүрээ, бичил уурхайн олборлолт явагдаж байгаа газрын элэгдэл эвдрэлийн хилийг тогтоож ажлын зурагт тэмдэглэх шаардлагатай.

2.4.2.Мэрэгчдийн хор хөнөөлд нэрвэгдсэн байдал

Энд үлийн цагаан оготно, царцаа зэрэг түгээмэл тархацтай хортон, мэрэгчдийг авч үзнэ. Хортон мэрэгчидийн хор хөнөөлд нэрвэгдсэн байдал, тархалт, хөнөөлийн мэдээллийг хянан баталгааны актад заавал тусгана.

Тал хээрийн бүсийн бэлчээр, тариалангийн талбайд өргөн тархсан хөнөөл учруулдаг мэрэгчдийн нэг бол үлийн цагаан оготно юм. Үлийн цагаан оготны тархалтыг явуулын ба талбайн аргыг ашиглан тодорхойлно.

Талбайн арга: тухайн нутгийг төлөөлөхүйц цэгт 25*25 м² талбайг 3-5 давталттай сонгон авч, бүх нүхийг бөглөж хоноод, өглөө нь онгойсон нүхний тоог гаргана. Үүнийгээ 16-аар үржүүлж 1 га-д ногдох эзэнтэй нүхний тоог гаргана. Мөн хэмжээний талбай сонгон авч дурангаар ажиглаж тоолоод ойролцоо тоог тогтоож болно.

Явуулын арга: 1 км урт ойролцоогоор 5 м өргөн талбайд бүх нүхийг бөглөж хоноод, өглөө нь онгойсон нүхний тоог гаргана.

1 га бэлчээр дэх эзэнтэй нүхний тоогоор үлийн цагаан оготны хөнөөлийн зэрэглэлийг тогтооно. Үүнд:

- 500 хүртэл хөнөөл багатай
- 500-1000 хөнөөлтэй
- 1000-1500 их хөнөөлтэй
- 1500- дээш нэн их хөнөөлтэй

Хортон шавьжийн хор хөнөөлд нэрвэгдсэн байдал

Энд үлийн цагаан оготно, царцаа зэрэг түгээмэл тархацтай хортон, мэрэгчдийг авч үзнэ. Хортон мэрэгчидийн хор хөнөөлд нэрвэгдсэн байдал, тархалт, хөнөөлийн мэдээллийг хянан баталгааны актад заавал тусгана.

Нэгж талбайн царцааны нягтралыг тооцоолох арга:

Цэгэн судалгааны аргаар төлөвлөсөн замналын дагуу талбайгаар явж 100 м тутамд нэг ам метр тооцоолох цэг авч газраас үсэрсэн буюу ниссэн, газарт үлдсэн царцааг тоолж дараах томъёогоор тооцоолж гаргана.

$$N = \frac{\sum n}{m}$$

N- нэг ам метр талбайн дундаж нягтрал

n- Нэг ам метр талбайд тоологдсон нийт царцаа

m- Тооцоолох цэгүүдийн тоо

2.Шавьжийн стандарт шүүрүүлийн аргаар сонгосон талбайг диагналын дагуу явж 50 алхам тутамд салхины зүгийн эсрэг шүүрүүлийн амсараар ургамлыг шүргүүлэн 10 цэгт даллан доорх томъёогоор тооцож гаргана.

$$X = \frac{N}{2r * L * P}$$

X- нэг ам метр талбайд тархсан царцааны (шавжийн) нягтрал

N- Шүүрүүлийн “р” даллалтанд орсон царцааны тоо

R- Шүүрүүлийн цагаригны радиус (0.3 м)

L- Шүүрүүлийн нэг далалтаар хамарч өнгөрөх замналын урт

1.2 метр урттай иштэй шүүрүүлийн нэг далалтын замналын урт нь 180 градусын өнцөгтэйгээр далласан бол 4.5 м, 120 градусын өнцгөөр далласан бол 3 м орчим тус тус байдаг.

P – шүүрүүлийн даллалтын тоо

Стандарт шүүрүүл нь 1.20 м урт иштэй, 60-70 см гүн урттай, цагиргийн диаметр нь 30 см байна.

3.Замналын аргаар судалгааг сийрэг ургамалтай газар 4 м, өтгөн ургамалтай газар 2 м өргөнтэй байвал зохино. Замналын тоо чиглэл нь судалгаа хийх талбайн хэмжээ, газрын гадаргаас хамаарна.

$$D = \frac{A * 10000}{B * V}$$

D- нэг га бэлчээрт тархсан царцааны дундаж тоо /ш

A- Замналын судалгаагаар цэг бүрээс илэрсэн царцааны нийлбэр

B- Замналын судалгаа хийсэн замын урт/м

V - Нүдэн баримжааны өргөн/м

Царцааны тархсан талбайн хэмжээ 100 га-аас бага байвал тооцоолох цэгүүд болон замнал хооронд тус бүр 100 м зайтай байж болно. 100 га-аас их хэмжээний талбайд

царцаа тархсан бол тооцоолох цэгүүд болон замналын хоорондох зайг 200 м хүртэл ихэсгэж болно.

$$A = \frac{a \cdot b \cdot c}{10000}$$

A- Судалгаа хийсэн талбайн хэмжээ, га

a-тооцоо хийсэн цэгүүдийн тоо, ш

b-тооцоо хийсэн цэгүүдийн хоорондох зай, м

c-замнал хоорондох зай, м

Эх сурвалж: Х.Батнаран, Монгол орны хадлан, бэлчээр, таримал ургамалд хөнөөл учруулдаг царцаа, 2015 он.

2.5.Бэлчээрийн газрын гадаргын ба хөрсний бохирдол

Газар ашиглалтын улмаас хөрс, ус, агаарт химийн хорт бодис хуримтлагдах, улмаар нэгээс нөгөөд дамжих нөхцөлтэй бол химийн бохирдолт гэж үзэж, лабораторын шинжилгээгээр тогтооно.

Сүүлийн жилүүдэд уул уурхайн ажил эрчимжтэй явагдаж байгаа, химийн бодисын хэрэглээ их байгаа тул хянан баталгааны ажлын хүрээнд бэлчээрийн хөрсний бохирдлыг заавал тодорхойлох шаардлагатай (ялангуяа хүн, малд хортой бодис хэрэглэж байгаа газарт).

Уурхай, бичил уурхай, ашигт малтмал олборлолт, хайгуул хийгдэж байгаа талбайн орчмын газарт (10 км зайд, салхин доод хэсгээс) мониторингийн цэг байгуулж, хөрсний дээж авч, хүнд металлын шинжилгээг хийнэ. Энэ шинжилгээг хийхдээ тухайн газар ашиглалт, хэрэглэж байгаа бодис, технолгиос хамааруулан тодорхойлох элементийг сонгож, шинжилгээнд хамруулна.

Хүнд металлын бохирдлын шинжилгээний дүнг “Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS5850:2008” стандарттай харьцуулж, тайланд тодорхой тайлбарласан байна.

Бэлчээрийн хөрсний бохирдолтод дараах бохирдлыг онцлон авч үзнэ. Үүнд:

- Хорт ургамлын ба бууцанд шимэгчийн тархалт
- Малын өвчин гарсан болон булшилсан газрын бохирдол
- Ахуйн бохирдол/хог хаягдал
- Мал угаалга хийсэн газрын бохирдол
- Уул уурхайн ашиглалтын нөлөөлөл /хөрсний органик биш (хүнд металл) бохирдуулагч бодисоор бохирдсон эсэх
- Хортон шавьж, мэрэгчдийн устгалтай холбоотой бохирдол /үүнтэй холбоотой бодисын бохирдол

Гэхдээ бохирдуулагч бодис хэрэглэсэн тухай тодорхой мэдээлэлгүй тохиолдолд хөрснөөс дээж авах, задлан шинжилгээ хийх ач холбогдолгүйг анхаарах хэрэгтэй.

Гадаргын ба хөрсний бохирдолт төвлөрсөн газар болон хот айлын буйр, худаг усны орчимд байж болзошгүй юм.

“Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд. MNS3298-1991” стандартын дагуу хөрсний дээжийг авна.

Өвөлжөө, хаваржааны бууцанд шимэгч хорхой, хамууны нянг холбогдох стандартын дагуу тодорхойлно.

Холбогдох байгууллагуудтай /Онцгой байдлын газар, Мал эмнэлэг, үржлийн газар, ХАА газар/ хамтран өмнө нь малын халдварт өвчин гарч байсан газруудыг тогтоож, зурагт тэмдэглэхээс гадна энэ талаарх мэдээллийг хянан баталгааны актад заавал тусгана.

2.6. Хээрийн ажлын тайлангийн агуулга

- **Нүүр хуудас** нь хүрээтэй байх ба дотор нүүр хуудсанд хянан баталгаа гүйцэтгэсэн аж ахуйн нэгжийн гүйцэтгэсэн ажилтнууд, захирал гарын үсэг зурж баталгаажуулан, тамга дарсан байна. (ЗАХИАЛАГЧИЙН НЭР /үсгийн хэмжээ 12, томоор/, АЖЛЫН НЭР /үсгийн хэмжээ 16, томоор/, ГҮЙЦЭТГЭГЧИЙН НЭР /үсгийн хэмжээ 14, томоор/, УЛААНБААТАР, ...ОН /үсгийн хэмжээ 12, томоор/)
- Гарчиг (хуудасны дугаартай байх)
- Ерөнхий мэдээлэл /хээрийн ажлын зорилго, зорилт, гэрээний дугаар, гэрээний хугацаа, мөрдсөн заавар, аргачлал /хуулийн заалтууд бичихгүй/, хээрийн ажил гүйцэтгэсэн аймаг сумын нэр, хугацаа, багийн бүрэлдэхүүн, ажлын хэсгийн оролцоо, орон нутгийн оролцсон байдал/
- Хээрийн судалгааны ажлын төлөвлөгөө, түүний гүйцэтгэлийн хувь, гүйцэтгэх хүмүүсийн нэр, ажил үүргийн хуваарь, хугацаа
- Хээрийн судалгааны маршрут, гүйцэтгэл, нэмэлт маршрут, эдгээрийн тайлбар
- Хээрийн ажилд ашигласан техник, багаж хэрэгсэл, ашигласан материалын жагсаалт
- Ажлын зургийн хуулбар, тайлбар, хээрийн нөхцөлд тодотгосон эсэх
- Хээрийн ажил гүйцэтгэхэд тулгарсан бэрхшээл, түүнийг шийдвэрлэсэн байдал
- Хавсралт (Аймаг, сумд болон бусад байгууллагатай харьцсан албан бичгийн хуулбар, Мониторингийн болон бусад цэгийн солбицолын жагсаалт, бичиглэлийн хуулбар, фото зураг, цэгийн хувийн хэрэг, тайланд засвар гарсан бол засварын жагсаалт, түүнийг зассан тухай тайлбар (хүснэгт))
- Баталгааны хуудас

2.7. Хээрийн ажлын захиалагчийн хяналт

Гүйцэтгэгч хээрийн ажлыг эхлэх, дуусгахдаа 7-оос доошгүй хоногийн өмнө захиалагчид мэдэгдэж, хээрийн ажлын тайланг ирүүлнэ.

Энэ нь хээрийн ажлын захиалагчийн хяналт хийх бэлтгэл ажлыг хангах, хээрийн ажлыг шалгах удирдамж боловсруулах, хүний нөөц, техникийн бэлэн байдлыг хангах зорилготой.

Захиалагчийн хяналт дараах байдлаар хийгдэнэ.

1. Аймгийн засаг даргын захирамжаар аймгийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын мэргэжилтэн, Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн, Сумын Засаг дарга, Газрын даамал, сумын мал үржлийн тасгийн дарга, мэргэжилтэн, сумын байгаль хамгаалагч гэсэн бүрэлдэхүүнтэй байгуулж, удирдамжийг батална. (Ажлын хэсэг гүйцэтгэгчийг хээрийн судалгаа хийх явцад хамтран явж хяналт хийж болно.)
2. Ажлын хэсэг хээрийн ажлыг газар дээр нь шалгаж, захиалагчийн хяналтын тайлан, дүгнэлтийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ. Тайланд ажлын хэсгийн бүрэлдэхүүн баталсан тушаал, удирдамжийн хуулбар, дутуу, зөрүүтэй хийгдсэн ажлын жагсаалт, нэмж хийх ажлын жагсаалт, сумын эрх бүхийн албан тушаалтнуудын оролцсон байдал зэргийг тусгасан байна.

Ажлын хэсгийн тайлан, дүгнэлт, мэргэжлийн хэлтсийн ажил шалгасан дүгнэлтийг үндэслэж хээрийн ажлын тайланг архивт хүлээн авна.

Мөн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас ажлын хэсэг байгуулж, удирдамжийн дагуу хээрийн ажлын гүйцэтгэлийг газар дээр нь түүвэрчлэн шалгана.

ГУРАВ. МАТЕРИАЛ БОЛОВСРУУЛАЛТЫН АЖИЛ

Материал боловсруулалтын ажлын хүрээнд бэлтгэл болон хээрийн судалгааны явцад бүрдүүлсэн мэдээллийг нэгтгэх, боловсруулалт хийх, дүн шинжилгээ хийх, зураглах ажил хийгдэнэ.

Тайлан боловсруулах ажил нь лабораторийн шинжилгээний дүгнэлтийг тайлбарлах, үндсэн мэдээллийг боловсруулах, дүгнэлт паспорт бичих, хавсралт хүснэгтийг боловсруулах, шаардлага бичих гэсэн хэсгээс бүрдэнэ.

3.1. Үндсэн үзүүлэлт

Дараах үзүүлэлтүүдийг лабораторийн шинжилгээгээр тодорхойлох бөгөөд Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуульд заасны дагуу итгэмжлэл авсан лабораторит хийлгэнэ. Үүнд:

А.Бэлчээрийн ургамлын химийн найрлага, шимт чанар:

1. Чийг
2. Протейн
3. Тослог
4. Эслэг
5. Азотгүй хандлаг бодис
6. Үнс

Эдгээр үзүүлэлтийг ХААИС-ын харъяа ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн лабораторт тодорхойлно.

Б. Бэлчээрийн хөрсний агрохимийн болон физик шинж чанар:

Лабораторын шинжилгээний үзүүлэлтүүд

Хүснэгт 9

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тодорхойлох арга
1	Ялзмаг	Хувь	Тюрины арга
2	Нитрит азот	мг/кг шороонд	1.0 н КСЕ-ийн хандмалын арга
3	Хөдөлгөөнт фосфор	мг/кг шороонд	Мачигиний арга
4	Хөдөлгөөнт кали	мг/кг шороонд	Дөлт фото метр
6	РН	Коэф	Потенциометр
7	Давсжилт	Хувь	Кондуктометр
8	Механик бүрэлдэхүүн	Хувь	Качинскийн арга

Давсжилтын шинж тэмдэг илэрсэн хөрсөнд давсжилтын шинжилгээг хийнэ.

Шинжилгээний дүнг лабораторийн тамга, тэмдгээр баталгаажуулан, эх хувиар эцсийн тайланд хавсаргана.

3.2.Нөлөөллийн үзүүлэлт

Бэлчээрт нөлөөлж байгаа үзүүлэлтийг дараах байдлаар ангилж тодорхойлно.

Нөлөөллийн үзүүлэлтийг тодорхойлох

Хүснэгт 10

№	Нөлөөллийн үзүүлэлт	Хэмжих нэгж	Тодорхойлолт	Тодорхойлох арга	Зурагт тэмдэглэх хэлбэр
1	Автогений	га	Хэрчигдлийн шигүү, нягтрал, тархалтаар нь тодорхойлох	Замын хоорондын зай 10 м-ээс ихгүй, зурвасын өргөн 50 м-ээс их бол автогений нөлөөлөлд тооцож өртсөн газрыг тодорхойлно.	Талбай
2	Техногений		Уул уурхай Замын карьер Бичил уурхай Цэргийн бааз, сургуулилтын газар Суурин газрын үлдэгдэл	Зам, Уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн хилээс гадна ашиглалтад өртсөн газрыг тодорхойлно. Мөн зөвшөөрөлгүй ашиглалтыг тодорхойлно. Ашиглалтын лицензийн хилийг давхцуулна.	Цэг, талбай
3	Бэлчээрийн		Царцаа	Тархалтын хүрээгээр	Талбай

	хортон мэрэгчдийн		Мэрэгчид	тодорхойлно.	
4	Бохирдсон		А зэрэглэлийн өвчний голомт, дарж булсан цэг /10 км/	онцгой байдал, сумын мал эмнэлэгээс цэгийг авч ашиглах ба зурагт цэг, талбайгаар дүрслэнэ.	Цэг, талбай
5	Доройтсон		бага, дунд, хүчтэй		Талбай
6	Элсний			Тархац/сансрын зураг Газар дээр нь зузааныг тодорхойлох Эх үүсвэр/элс үүссэн нөхцөл байдал/салхи, талхлагдал, ашиглалтаас үүсэх	Цэг, талбай
7	Хөрсний шугаман эвдрэл		Үерийн улмаас	Стандарт ашиглана. Зурагт цэгээр тэмдэглэнэ.	Цэг, талбай
8	Алслагдсан		Байгалийн саад бэрхшээлийн улмаас ашигладаггүй бэлчээр /даваа, гол, суурьшлаас хэт хол/	Зураг дээр	Талбай
9	Худаг, усны хүрэлцээгүй		Гадаргын усан хангамж	Усжуулагдсан бэлчээрийн талбайг тодорхойлох аргачлал /ХААХҮЯ-наас баталсан/-аар	Талбай
10	Бэлчээрийн улирлын ашиглалт		Зун намрыг + Өвөл хаврыг -	+, - гэж тэмдэглэнэ.	Талбай
11	Зун намар	Малд идэгдэх ургац, цн/га	0 см-ээс дээш хайчилсан ургац		Талбай

3.3. Хянан баталгааны ажлын үндсэн мэдээллийг боловсруулах

Үндсэн мэдээллийг хүснэгт хэлбэрээр боловсруулах ба хүснэгт тус бүрийг өмнө хийсэн хянан баталгааны ажлын үр дүнтэй харьцуулан тайлбарлаж тайланд оруулна. Хүснэгт болон тайланг заавал Arial фонтоор бичсэн байна.

Үндсэн мэдээлэлд дараах мэдээллүүд орно. Үүнд:

1. Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын дэлгэрэнгүй үзүүлэлт
2. Нэгж талбарын дүгнэлт
3. Нөлөөллийн үзүүлэлт
4. Мониторингийн (дээж авсан, бичиглэл хийсэн) цэгийн дэлгэрэнгүй хүснэгт
5. Мониторингийн цэгийн хувийн хэрэг

Дэлгэрэнгүй үзүүлэлтийн хүснэгт нийт 29 үзүүлэлтээс бүрдэнэ.

1. Нэгж талбарын дугаар: B220100001
2. Мониторингийн цэгийн дугаар: M1
3. Бичиглэлийн цэгийн дугаар: B1
4. Зураг дээрх индекс: 1
5. Бэлчээрийн төрлийн ангиллын шифр: Ө – I -1 -1
6. Бэлчээрийн төрлийн нэр: Хагт, Хаг-хөвдөт
7. Талбай, га: 19595.3
8. Бүрдлийн хувь: Хэрэв бэлчээрийн төрөл дангаараа бол 100 гэж бичигдэнэ. Холимог бол зохих хувийг бичнэ.
9. Тусгац бүрхэц, %: Бичиглэл хийсэн болон мониторингийн цэг дээр өөрчлөх боломжтой.
10. Зүйлийн тоо, ш: Бичиглэл хийсэн болон мониторингийн цэг дээр өөрчлөх боломжтой.
11. Төрх байдал: га-аар тэмдэглэнэ. Энэ талбайн хэмжээ нөлөөллийн үзүүлэлтийн нийт га талбайг үзүүлнэ.
12. Нөлөөллийн үзүүлэлтүүд, га: Талбайн хэмжээг зурагт тодорхойлсоноор тэмдэглэнэ.
13. Ашиглалтыг зун-намрын, өвөл-хаврын гэж ялгаж тэмдэглэнэ.
14. Бодит ургац, цн/га: Зун намрын болон өвөл хаврын ургацыг ашиглах бол дундаж ургацыг дээрх 2 ургацын дунджаар бичнэ. Харин бичиглэл хийсэн болон мониторингийн цэгийнхийг газар дээрх хэмжилтийн үр дүнгээр бичигдэнэ.
15. Тэжээлийн шимт чанар, солилцох энерги, МДЖ: лабораторит тодорхойлно.

..... аймгийн (аймгийн код) сум (сумын код)-ын Бэлчээрийн төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны дэлгэрэнгүй үзүүлэлт

Хүснэгт 11

№	Нэгж талбарын дугаар	Мониторингийн цэгийн дугаар	Бичиглэлийн цэгийн дугаар	Үндсэн үзүүлэлт							Нөлөөллийн үзүүлэлтүүд, га													Малд идэгдэх ургац, цн/га	Тэжээлийн шимт чанар, солилцох энерги, МДЖ					
				Зураг дээрх индекс	Бэлчээрийн төрлийн ангиллын шифр	Бэлчээрийн төрлийн нэр	Талбай, га	Бүрдлийн хувь, %	Тусгаг бүрхэц, %	Зүйлийн бүрэлдэхүүний тоо, ш	Төрх байдал, га	Автогени	Техногени	Хортон мэрэгчийн нөлөө	Бохирдсон	Бага зэрэг доройтсон	Дунд зэрэг доройтсон	Хүчтэй доройтсон	Элсний нүүлтэд өртсөн	Усны эвдрэлд орсон	Гуу жалга гарсан	Алслагдсан	Худаг усны хүрэлцээгүйгээс ашигладаггүй			Ашиглалт				
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	

Төрх байдлын зэрэглэлийг (GIS, Excel) хүснэгтэнд тэмдэглэх хэлбэр

Хүснэгт 12

№	Төрх байдал	Зэрэглэл	shp	Excel
1	Сөөгтэй	Их	c3	c3
2		Дунд	c2	c2
3		Бага	c1	c1
4	Довонтой	Их	d3	d3
5		Дунд	d2	d2
6		Бага	d1	d1
7	Чулуутай	Их	ch3	ch3
8		Дунд	ch2	ch2
9		Бага	ch1	ch1
10	Цэвэр		0	0

..... аймгийн (аймгийн код) сум (сумын код)-ын бэлчээрийн төлөв байдал,
 чанарын улсын хянан баталгааны хөрс, ургамлын дээжний шинжилгээний нэгдсэн үзүүлэлт
 Хүснэгт 13

№	Нэгж талбарын дугаар	Мониторингийн цэгийн дугаар	Бичиглэлийн цэгийн дугаар	Хөрсний шинжилгээний үзүүлэлт				Ургамлын шинжилгээний үзүүлэлт								
				Хөрсний ялзмаг	Хөрсний орчин	Нитрат азот	Хөдөлгөөнт фосфор	Хөдөлгөөнт кали	Механик бүрэлдэхүүн	Хүнд металлын шинжилгээ	чийг	протейн	эслэг	үнс	Хүчилд уусдаггүй ислэг	Шүлтэнд уусдаггүй ислэг

Нөлөөллийн үзүүлэлтийн товчоо (хянан баталгааны акт бичихэд ашиглана.)

Хүснэгт 14

Төрх байдал нөлөөллийн үзүүлэлтүүд	Сөөгтэй			Довонтой			Чулуутай			Өвслөг ургамалтай		Бэлчээрт тохиромжгүй		Дүн /га/
	нэгж талбарын дугаар	талбай га	нэгж талбарын дугаар	талбай га	нэгж талбарын дугаар	талбай га	нэгж талбарын дугаар	талбай га	нэгж талбарын дугаар	талбай га	нэгж талбарын дугаар	талбай га		
1														
Хүчтэй доройтсон														
Дунд зэрэг доройтсон														
Бага доройтсон														
Автоген														
Техноген														
Хортон мэрэгчид														
Гуу жалга														
Усны авдрал														
Элсний нүүлт														
Бохирдолт														
Алслагдсан														
Ашиглагддаггүй														
Хэвийн буюу өөрчлөлтгүй														
Дүн /га/														

Бэлчээрийн даац тодорхойлох:

Бэлчээрийн нэгж талбайд тодорхой хугацааны турш бэлчих мал, өвсөн тэжээлтэн амьтны тоогоор илэрхийлэгддэг хэмжигдэхүүнийг бэлчээрийн даац гэнэ /Бэлчээр тэжээлийн хүрээлэн/.

Бэлчээрийн ургац жил жилд байнга хэлбэлздэг учир даацыг өнтэй, хэвийн, гантай жилүүдээр ялгаварлан тооцоолно.

Бэлчээрийн даацыг зөв тогтоохын тулд бэлчээрээс аливаа төрлийн мал, амьтны өдөрт идэх өвсний хэмжээ, мал, амьтны тоо, бэлчээрийн ургац, бэлчээр ашиглах хугацаа, бэлчээрийн талбайн хэмжээг мэдсэн байх шаардлагатай.

Хүснэгт 15

Малын төрөл	Улирал			
	зун	намар	өвөл	хавар
Адуу	7,8	8,1	6,5	5,8
Тэмээ	14,1	13,0	8,4	9,9
Үхэр	8,7	9,7		7,4
Хонь	1,6	1,8	1,1	1,1
Ямаа	1,3	1,4	1,0	1,0

Бод, бог малын өдөрт бэлчээрээс идэшлэх өвсийг, нэг хонины өдрийн нормтой жишиж гаргадаг.

Төрөл бүрийн малыг хонин толгойд шилжүүлэх итгэлцүүр
/Газрын төлбөр ногдуулах аргачилсан заавар, 2011 он/

Хонин толгойд шилжүүлэх коэффициентийг малын тэжээлийн хүрэлцээ, хангамж, бэлчээрийн даацыг тодорхойлоход ашиглана.

Хүснэгт 16

Малын төрөл	Адуу	Тэмээ	Үхэр	Хонь	Ямаа
Хонин толгойд шилжүүлэх илтгэлцүүр	7,0	5,0	6,0	1	0,9

Бэлчээрийн нэг га талбайн даацыг $БД=У/ӨХ$ томъёогоор бодно.

БД- Бэлчээрийн даац

У- Бэлчээрийн бодит ургац, ц/га

Ө- нэг малын бэлчээрээс өдөрт идэх өвс, кг

Х- Нэг өрх айлын бэлчээр ашиглах хугацаа, хоногоор

Бэлчээрийн даац

Хүснэгт 17

Нийт малын тоо	адуу	үхэр	тэмээ	хонь	ямаа	Малын тоо /хонь толгойд шилжүүлсэнээр/	Жилд шаардагдах тэжээлийн нөөц, мян.цн	Даац ашиглалт - ,+ %
1	2	3	4	5	6	7	8	9

Бэлчээрийн чадавхи тодорхойлох:

Бэлчээрийн даацыг бэлчээрийн ургац, нэг малын хоногт бэлчээрээс идэх өвс, хот айл, өрхийн малын тоо, бэлчээр ашиглах хугацааг үндэслэн шаардагдах бэлчээрийн талбайгаар тохируулж болно.

БТ=ӨХС/У

БТ-шаардагдах бэлчээрийн талбай, га

С-Малын тоо

Ө-Нэг малын бэлчээрээс идэх өвс, кг

Х- хугацаа, хоног

Бэлчээрийн багтаамж гэдэг нь нэг хонин толгойд ногдвол зохих бэлчээрийн талбайг хэлнэ.

Бэлчээрийн чадавхи

Хүснэгт 18

Бэлчээрийн нийт талбай /га/	1га бэлчээрийн малд идэгдэх ургац /цн/	Тэжээлийн нөөц /мян. цн/	1га бэлчээрт байх мал /хонь толгой/	Бэлчээрийн чадавхи хонь/толгой
1	2	3	4	5

Бэлчээрийн тэжээлийн нөөц

Хүснэгт 19

Зураг дээрх индекс	Бэлчээрийн төрлийн ангиллын шифр	Бэлчээр хадлангийн анги, бүлэг, төрлийн нэр	Талбай, га	Бодит хуурай ургац, цн/га			Тэжээлийн нөөц, мян.цн
				Зун, намар	Өвөл, хавар	Жилийн дундаж	
1	2	3	4	5	6	7	8
Дундаж							

3.4.Өмнө хийсэн хянан баталгааны үр дүнтэй харьцуулах

Өмнө хийсэн хянан баталгааны үр дүнтэй харьцуулж, өөрчлөлтийг тогтоох нь тухайн сумын бэлчээрийн хянан баталгааны акт бичих гол эх сурвалж нь болно. Харьцуулалтыг хавсралт 6-д заасан хүснэгтээр хийж тайлбарыг тайланд дэлгэрэнгүй тусгана.

3.5.Мониторингийн цэгийн хувийн хэрэг бүрдүүлэх

Хувийн хэргийг хавсралт 5-д заасны дагуу бүрдүүлж, тайланд хавсаргана.

3.6.Хянан баталгааны дүгнэлт бичих

Хянан баталгааны дүгнэлтийг 2 хэлбэрээр бичнэ. Үүнд:

1. Мониторингийн цэг бүхий нэгж талбарын дүгнэлт
2. Ижил төрлийн бэлчээр бүхий нэгж талбаруудыг багцалсан дүгнэлт

Хянан баталгааны дүгнэлтэд хэмжилт, задлан шинжилгээний дундаж тоон утга ба түүний үнэлэлт дүгнэлт заавал бичигдэнэ.

3.7.Хянан баталгааны акт бичих

Хянан баталгааны акт нь Газрын тухай хуулийн 50, 51-р заалтыг хэрэгжүүлэх, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх, газар зохион байгуулалтын арга хэмжээг тогтоож үүрэгжүүлэхэд чиглэнэ.

Хянан баталгааны актыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын ХАА газрын хянан баталгааны асуудал хариуцсан мэргэжилтэн сум бүрээр болон аймгийн хэмжээгээр гаргана.

Хээрийн ажиглалт хэмжилт, лабораторийн задлан шинжилгээний дүнг үндэслэн актыг гаргах бөгөөд дараах загварын дагуу гаргана.

... аймгийн ... сумын бэлчээрийн хянан баталгааны акт

Хүснэгт 20

Газрын нэр, нэгж талбар	Цаашид бэлчээр ашиглалтад тавигдах шаардлага	талбай, га

Актыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга буюу хянан баталгааны улсын ерөнхий шинжээч баталгаажуулан, тухайн орон нутгийн захиргаа болон ХАА-н асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад албан ёсоор хүргүүлнэ.

Ялангуяа төлөв байдлын ба чанарын өөрчлөлт гарсан тохиолдолд ихээхэн анхаарал тавих хэрэгтэй. Өөрчлөлтийн үндэслэл ба зэрэглэл, шалтгаан, түүнд

нөлөөлсөн хүчин зүйл, эерэг ба сөрөг талыг тодорхой баримт үндэстэй актад тусгана.

Мөн хээрийн ба материал боловсруулалтын хугацаанд ажиглагдаж байсан буюу тэмдэглэгдсэн хэдийгээр дүгнэлт гаргах үндэслэл болохооргүй ч гэсэн дараагийн хянан баталгааны ажилд мөн цаашдын газар ашиглалт, хамгаалалтанд анхаарах газрын төлөв байдал, чанарын онцлогийг тусгасан байна.

Акт хэдий чинээ дэлгэрэнгүй олон талаас нь авч үзсэн байх тутам төдий чинээ сайтар үндэслэлтэй болно. Хянан баталгааны дүгнэлтэд хавсаргах зураг ба шаардлагын бүрдэлтээр тухайн хянан баталгааны ажлын чанар тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл хянан баталгааны дүгнэлт, зураг, акт нь хянан баталгааны нэгдсэн тодорхойлолт болно.

3.8. Нэгж талбарын сүлжээний зураг боловсруулах

Хянан баталгааны нэгж талбарын сүлжээний тоон зураг боловсруулах ажил дараах хэсгээс бүрдсэн байна. Мэдээлэл оруулахдаа заавал Arial фонт ашиглана.

1. Зураглах
2. Хүснэгтэн мэдээллийг оруулах
3. Зургийн эх бэлтгэх, хэвлэх

3.8.1.Зураглах

1. Хянан баталгааны нэгж талбарын сүлжээний тоон зургийг Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан WGS-84 солбицол, UTM тусгагт зураглана.
2. Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас аймаг, сумын хилийг тоон хэлбэрээр авч ашиглах бөгөөд сумын төвийн тэг гортигийг тухайн сумын захиргаанд баримталж байгаа хилээр зураглана.
3. Цэг, шулуун, талбай хэлбэрээр зураглах ба эдгээр нь орон зайн мэдээллийн сангийн шаардлагыг хангасан хүснэгтэн мэдээллийн болон таних тэмдгийн загвартай байна.
4. Хянан баталгааны өгөгдлийн сангийн загварыг үндэсний орон зайн мэдээллийн санд нийцүүлэн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.
5. Тоон зургийн топологийн алдааг засварласан байна.

3.8.2.Хүснэгтэн мэдээлэл оруулах

Хянан баталгааны нэгж талбарын сүлжээний зургийн давхарга бүр хүснэгтэн мэдээлэлтэй байх бөгөөд бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны өгөгдлийн сангийн загварын дагуу оруулна. Хүснэгтэд мэдээллийг заавал Arial фондоор бичнэ.

1. Бэлчээрийн төрөл буюу хянан баталгааны нэгж талбар
2. Бага доройтсон бэлчээр
3. Дунд зэрэг доройтсон бэлчээр

4. Хүчтэй доройтсон бэлчээр
5. Сөөгтэй бэлчээр
6. Довонтой бэлчээр
7. Чулуутай бэлчээр
8. Мониторингийн цэг
9. Хөрсний дээж авсан цэг
10. Бичиглэлийн цэг
11. Нөлөөллийн үзүүлэлтийн мэдээлэл

Гүйцэтгэгч хянан баталгааны орон зайн мэдээллийг үндэсний орон зайн мэдээллийн санд оруулах бөгөөд газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын орон зайн мэдээлэлийн асуудал хариуцсан нэгжээр дүгнэлт гаргуулж, эцсийн тайлангийн ард хавсаргана.

3.8.3.Зургийн эх бэлтгэх

Хил залгаа аймаг, сумдын нэгж талбарын сүлжээний зургийн хил зааг уялдаж байгаа /тохирч байгаа/ эсэхийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын орон зайн мэдээлэлийн болон мэргэжлийн хэлтэс хамтран шалгаж дүгнэлт гаргана.

Зургийн эх бэлтгэхдээ заавал текст, тоог Arial фондоор, тохирох үсгийн хэмжээгээр бичнэ. Жишээ нь:

- зургийн нэр 14 (үсгийн хэмжээ)
- булангийн хүснэгт 10-аас доош (үсгийн хэмжээ)
- зургийн тайлбар 12-оор (үсгийн хэмжээ)
- таних тэмдэг, нэгж талбарын дугаар, мониторингийн цэгийн дугаарыг тохирох үсгийн хэмжээгээр бичнэ.

Хянан баталгааны зургийн үндсэн өнгө нь бэлчээрийн төрөлүүдийн өнгө байх бөгөөд үүнийг Монгол орны бэлчээр, хадлангийн ангилааны өнгө ба кодоор өгнө.

Зургийн нэрийг өгөхдөө Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код (MNS5641-0-2006 2х, MNS5641-1-2006 6х, MNS5641-2-2006 34х, MNS5641-3-2006 47х) стандартыг ашиглана. Жишээ нь: *Архангай аймгийн (аймгийн код) Ихтамир сум (сумын код)-ын бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны нэгж талбарын сүлжээний зураг*

Зургийн суурь таних тэмдгийг хийхдээ Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан дараах стандартыг таних тэмдэгт ашиглана. Үүнд:

- “Байр зүйн болон дэвсгэр зургийн загвар сан, таних тэмдэг. Масштаб: 1:500, 1:1000, 1:2000, 1:5000. MNS 6702:2017”,
- “Байр зүйн зургийн загвар сан, таних тэмдэг. Масштаб: 1:25000, 1:50000, 1:100000. MNS 6703:2017”

ЗУРАГТ НЭГЖ ТАЛБАРЫН ДУГААР БИЧИХ

Зурагт нэгж талбарын дугаарыг 8/99а/2359 гэж бичнэ. Энэ нь нэгж талбарын дугаар, бэлчээрийн индекс, талхлагдлын зэрэг, талбайн хэмжээ гэсэн дарааллаар бичнэ. Харин нэмэлтээр өөр бэлчээрийн индекс бичигдэх тохиолдолд голлох индексийг урд нь бичнэ. Жишээ нь 31/9+214б/3339.0 г.м.

Анхны хянан баталгааны нэгж талбарын дугаар өөрчлөгдөхгүй байна.

Харин шинэ нэгж талбарыг хамгийн сүүлийн нэгж талбарын дугаарлалтаас эхлэн дугаарлана.

Хэрэв нэгж талбар хуваагдсан бол а, б гэж ялгах нэмэлт дугаар өгнө. Өөрөөр хэлбэл 011а/228/300, 011б/228/200 гэж дугаарлана.

Хэрэв өмнөх хянан баталгааны нэгж талбарын дугаар өөр хэлбэрээр өгөгдсөн бол түүнийг олох хүснэгтийг тайланд тусгана. Жишээ нь:

Хүснэгт 21

№	Газрын нэр	Өмнөх нэгж талбарын дугаар	Одоо өгч байгаа нэгж талбарын дугаар
1	Нэмнэн	011/228/500	011а/228/300, 011б/229/200

ЗУРАГТ ХҮРЭЭ ОРУУЛАХ

Нэгж талбарын сүлжээний зурагт газар зүйн солбицолын тор хийх бөгөөд зураас нь харагдахгүй байна.

ЗУРАГТ ТАЙЛБАР ХҮСНЭГТ ОРУУЛАХ

Зурагт дараах 2 мэдээллийг хүснэгтээр оруулна. Үүнд:

1. Зургийн тайлбар
2. Мониторингийн цэгийн шинжилгээний дүн

Зургийн тайлбар

Хүснэгт 22

Зураг дээрх индекс	Ангилалын шифр	Бэлчээрийн төрөл	Нийт талбай, га
	Ө	Өндөр уулын бэлчээр	3339.0
1	Ө-I-1-1	Хагт, хаг- хөвдөт	622.0

1992 онд Газрын бодлогын хүрээлэн /хуучин нэрээр/-ээс баталсан “Монгол орны бэлчээр хадлангийн ангиллаа”-д заасан дэс дарааллаар ангилалын шифрийг бичиж оруулна. Зургийн тайлбар, тайлангийн хүснэгт адил байна.

Зурагт мониторингийн, бичиглэл хийсэн, дээж авсан цэгийн мэдээллийг дараах хүснэгтээр нэгтгэж оруулна.

Цэгийн мэдээлэл

Хүснэгт 23

Нэгж талбарын дугаар	Талбайн хэмжээ, га	Цэгийн дугаар	Солбицол	Ургамлын мэдээлэл	Хөрсний мэдээлэл
		M1			
		B1			
		D1			

Нэгж талбарын зургийн баруун доод буланд зургийг хийсэн болон шалгасан мэдээллийг оруулна. Схем болон томруулсан зурагт оруулах шаардлагагүй.

Булангийн хүснэгт

Хүснэгт 24

Ажлын нэр: ... аймгийн сумын бэлчээрийн төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа							
Захиалагч байгууллагын нэр: ГЗБГЗЗГ				Гүйцэтгэгч байгууллагын нэр/тамга: "Глобус" ХХК			
Шалгасан	Албан тушаал	Нэр	Гарын үсэг	Гүйцэтгэсэн	Албан тушаал	Нэр	Гарын үсэг
	Хэлтсийн дарга				Захирал		
	Мэргэжилтэн				Зургийн боловсруулалт хийсэн		
Архив, мэдээллийн төвд хүлээлгэн өгсөн огноо: 2018.03.25				Масштаб: 1:100000		Хэвлэсэн хувь: 3	

3.8.4.Зураг хэвлэх

Бэлчээрийн хянан баталгааны зураг томоохон цаасан дээр хэвлэх шаардлага үүсдэг тул дараах 3 хэлбэрээр 3 хувь (архивт, аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын архивт, сумын Газрын даамлын ажлын хэрэгцээнд) хэвлэнэ.

1. Хянан баталгааны зургийг А3 цаасанд багтааж хэвлэх (булангийн хүснэгттэй байх, бусад хүснэгт багтах боломжгүй бол оруулахгүй байх, энэ зургийн зүүн дээд буланд тухайн сум аймгийн аль хэсэгт байрласан тухай тойм зураг хийсэн байна)
2. Хянан баталгааны зургийг А3 цаасанд (А3 хэмжээгээр тор татсан, торны нүдийг дугаарласан) багтааж хэвлэх
3. Хянан баталгааны зургийг А3 цаасанд багтаан (хуваасан тор бүрээр) 1:100000 масштабаар хэвлэх

Хэвлэсэн зургийг дэс дарааллын дагуу А3 цаасны хэмжээтэй стандарт хайрцагт (архивын) хийж хүлээлгэн өгнө.

3.9.Хянан баталгааны ажлын тайлан

Тайлан бичих

Тайланг дор дурьдсан бүтцийн дагуу Агrial фондоор, үсгийн 12 хэмжээтэй, мөр хоорондын зай 1.5-аар бичнэ.

Тайланг бичихдээ үг үсгийн алдаагүй, утга найруулга сайтай, 1 санааг давхардуулахгүй бичихэд анхаарна. Тооны орон таслалын ард 1 байхаар бичнэ.

Бусад эх сурвалжаас иш татсан бол өгүүлбэрийн ард дөрвөлжин хаалтанд дугаарыг (ашигласан материалын жагсаалтын дугаар) бичнэ.

- (Гадна нүүр хуудас (ЗАХИАЛАГЧИЙН НЭР /үсгийн хэмжээ 12, томоор/, АЖЛЫН НЭР /16, томоор/, ГҮЙЦЭТГЭГЧИЙН НЭР /14, томоор/, УЛААНБААТАР, ...ОН /12, томоор/) Захиалагчийн нэр, ажлын нэрийн доор тухайн аймгийн сумын байршлыг харуулсан зургийг оруулж болох ба аймаг бүрийн тайланг өөр өнгийн хавтсанд хийнэ.
- (Дотор нүүр хуудас (ЗАХИАЛАГЧИЙН НЭР /үсгийн хэмжээ 12, томоор/, АЖЛЫН НЭР /16, томоор/, ГҮЙЦЭТГЭГЧИЙН НЭР /14, томоор/, оролцсон хүмүүсийн ажлын байрны нэр ба мэргэжилтэний нэр, гарын үсэг, УЛААНБААТАР, ...ОН /12, томоор/) Гарчиг (хуудасны дугаартай байх)
Зургийн жагсаалт (дугаар, хуудасны дарааллаар)
Хүснэгтийн жагсаалт (дугаар, хуудасны дарааллаар)
Графикийн жагсаалт (дугаар, хуудасны дарааллаар)
- **Үндэслэл** (ажил гүйцэтгэх үндэслэл, ажлын зорилго, зорилт, гэрээний дугаар, гэрээний хугацаа, ашигласан журам, заавар, аргачлал /хуулийн болон журмын заалтууд бичихгүй/-ийн жагсаалт, хамтран ажилласан байгууллага, хүмүүс, тэдний гүйцэтгэсэн үүрэг, хээрийн судалгааны ажлын төлөвлөгөө, маршрут, гүйцэтгэл, гүйцэтгэсэн хүмүүс, ажил үүргийн хуваарь, гүйцэтгэсэн хугацаа, ашигласан техник, багаж хэрэгслийн жагсаалт, хуучин хянан баталгаа хийсэн талаарх мэдээлэл, товч үр дүн зэрэг мэдээллийг агуулна.)
- **Хянан баталгааны арга зүй** (арга зүйг схемээр харуулж тайлбарлах, цуглуулсан мэдээлэл, эх сурвалж, ажлын үе шат бүрт хийсэн ажлын жагсаалт, хиймэл дагуулын зураг боловсруулсан арга зүй, ажлын зураг, түүний бүрдэл, тэдгээрийн эх сурвалж)
- **Байгаль, нутаг дэвсгэрийн тухай мэдээлэл** (газар зүйн байршил, газрын гадарга, цаг уур, хөрсөн бүрхэвч, ургамалжилт)-ийг эх сурвалжийн хамт бичнэ. 1:100000 байр зүйн зураг болон агаар сансрын зураг, гадаргын өндөржилтийг зургаар харуулна. Уур амьсгалын мэдээллийг хамгийн ойр байрлах станцын сүүлийн 5-аас доошгүй жилийн мэдээллийг ашиглан бичнэ. Хөрсний шинж чанар, ургамалжилтын мэдээллийг хамгийн сүүлийн үеийн эх сурвалж ашиглан бичнэ. Зарим нэг ном сурах бичиг, судлаачийн бүтээлээс ишлэл авсан тохиолдолд уг өгүүлбэрийн ард нь хаалтанд, бүтээл болон номны нэр, зохиогч, оныг дурьдаж ашигласан материалын жагсаалтад оруулна.)

- **Бэлчээр ашиглалтын одоогийн байдал.** (Бэлчээрт тархсан нийт төрөл, талбайн хэмжээ, бэлчээр тэжээлийн нөөцийг тооцох, бэлчээрийн багтаамж, даацыг тодорхойлох, сүүлийн 5 жилээр малын тооны өсөлтийг малын төрлөөр гаргах, зун-намрын, өвөл-хаврын бэлчээрийн байршлыг тодорхойлох, тахлагдалын зэрэглэлийг тайлбарлах, гол нөлөө үзүүлж байгаа хүчин зүйлийг тайлбарлах, тайлбаруудыг баримт нотолгоонд суурилж хийх,)
- **Бэлчээрийн ургамалжил, түүний өөрчлөлт** (Бэлчээрийн ургамалжлын ерөнхий төрхийг тодорхойлох ба өмнө хийсэн хянан баталгааны ажлын талаар товч дүгнэлт өгсөн байна. Төлөв байдлын өөрчлөлт хур тунадас, температураас шууд хамааралтай байдаг тул дүгнэлт хийхдээ уур амьсгалын хүчин зүйл болон цаг уурын үзүүлэлтүүдийг хамтад нь авч үзэх хэрэгтэй. Мөн бэлчээрийн ургамлын тэжээлийн шимт чанарын талаарх мэдээллийг оруулна. Хянан баталгааны үндсэн үзүүлэлт, нөлөөллийн үзүүлэлт, хөрс, ургамлын шинжилгээний үр дүнг тайлбарлана. Бүсийн дундаж утгатай болон бусад судлаачдын бүтээлтэй харьцуулан дүгнэнэ.)
- **Мониторингийн цэгийн мэдээлэл** (Цэгийн жагсаалт, солбицол, цэг дээр хийгдсэн ажилбар, цэг байгуулсан үндэслэлийг цэг бүрээр тайлбарлах, цэгийн байршлыг сумын зурагт тоймоор харуулах, мониторингийн цэгийн бичиглэл, фото зураг, дээжний лабораторийн шинжилгээний дүн нэгтгэн харуулна. Харин бичиглэл, дүгнэлт зэргийг тайлангийн хавсралтад оруулна.)
- **Бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах шаардлага** (хянан баталгааны ажлын үр дүнд үндэслэн бэлчээр зохион байгуулалтын гол арга хэмжээг тухайн сумын бэлчээр ашиглалтын онцлог, өөрчлөлтийн чиг хандлагатай уялдуулан бичнэ. Зарим нэгж талбарыг тусгайлан арга хэмжээг зөвлөнө. Актыг сум бүрт адил бичихгүй байхад анхаарна.)
- **Дүгнэлт** (энэ дүгнэлт нь тайлангийн дүгнэлт бөгөөд сумын хэмжээнд нийт бэлчээрийн хэмжээ, хэдэн нэгж талбарт, хичнээн га талбайд хуваагдсан эсэх, ерөнхий ургамалжилт, байгаль газар зүйн онцлог, төлөв байдлын өөрчлөлтийн шалтгаан, өмнөх хянан баталгааны үр дүнгээс ямар байдлаар зөрсөн, түүний шалтгааныг тайлбарлах, үндсэн болон тусгай шаардлагыг тайлбарлах, хэрэгжүүлэх зөвлөмжийг товч дурьдсан байна. Дүгнэлт нь тайланд дурьдсан тоон утгаар баталгаажсан байдлаар бичигдсэн байна.)
- **Ашигласан материалын жагсаалт** /цагаан толгойн дарааллаар/, эх сурвалжийн нэр, он, хуудсын дугаар, хэвлэгдсэн газрын нэр, цахим хаяг
- **Хавсралт** (албан тоотын хуулбар, бэлтгэл, хээрийн ажлын дүгнэлт, акт, лабораторийн шинжилгээний баталгаажуулсан дүн, паспорт буюу газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлт, мониторингийн цэгийн хувийн хэрэг, бичиглэл, дээж авсан цэгүүдийн мэдээлэл)
- Баталгааны хуудас

Газрын кадастрын мэдээллийн сан үнэн хэрэгтээ хянан баталгааны материалыг нэгтгэн дүгнэсний үр дүнд бий болно. Энэ утгаар л материалыг нэгтгэн боловсруулан баталгаажуулна.

Хээрийн ажлын тэмдэглэл ажиглалт, хэмжилтийн анхдагч материал, талбайд ашигласан, дээж авсан, хэмжилт хийсэн, цэг тэмдэглэсэн, мөн түүнчлэн аливаа өөрчлөлтийг тусгасан ажлын зураг зэргийг хүлээлгэн өгнө.

Тоон файлыг хуулбарлах

Тоон зураг, тайлан, хавсралтыг 3 хувь CD-д хуулбарлана. CD-ний нүүрийг доорх загвараар хийх бөгөөд 1 сумын материалыг (фолдерийн нэр: *Argalant sum*) 1 фолдер үүсгэн, дараах фолдерыг дарааллын дагуу хадгална.

А. Зураг

1. Нэгж талбарын сүлжээний зураг, “jpg”, 1:100000 масштабаар (файлын нэр: *Argalant_jpg*)
2. Хуваалга хийсэн схем зураг, “jpg”, А3 цаасны хэмжээгээр (файлын нэр: *Argalant_scheme*)
3. Хувааж хэвлэсэн зураг, “jpg”, А3 цаасны хэмжээгээр (файлын нэр: *Argalant_jpg1*)

Б.Тайлан

4. Үндсэн тайлан, Arial фонт, “doc”, “pdf” (файлын нэр: *Argalant_tailan*)
5. Нэгдсэн хүснэгт, “exc” (файлын нэр: *Argalant_husnegt1*)
6. Нөлөөллийн товчоо, “exc” (файлын нэр: *Argalant_husnegt2*)
7. Дүгнэлт, паспорт (файлын нэр: T2116000467)

В.Хавсралт материал

8. Дараах мэдээллийг нэгж талбарын дугаараар 1 фолдерт хийнэ. Үүнд:
 - Хээрийн судалгааны фото зураг, “jpg”, (файлын нэр: *Heer_photo*)
 - Скайнердсан ургамлын бичиглэл, “pdf” (файлын нэр: *urgam_bichiglel*)
 - Скайнердсан хөрсний бичиглэл, “pdf” (файлын нэр: *hurs_bichiglel*)
 - Скайнердсан лабораторын шинжилгээний дүн, “pdf”, (файлын нэр: T2116000467)
9. Боловсруулалт хийсэн агаар, сансрын зураг (фолдерийн нэр: *Argalant_хиймэл дагуулын нэр*)
10. Arc GIS ажлын файл (фолдерийн нэр: *Argalant_mxd*)
11. “gdb” өргөтгөлтэй дата бааз (фолдерийн нэр: *Argalant_gdb*)
12. Топологи файл (фолдерийн нэр: *Argalant_top*)



13. Байрзүйн элемент (фолдерийн нэр: *Argalant_topo*, файлын нэр: *Argalant sum_top, davaa, owoo,*)

Файлыг дээрх дэс дарааллаар дугаарлан эрэмбэлж, сум тус бүрээр (цагаан толгойн дарааллаар) фолдер үүсгэн, CD/DVD-д хуулбарласан байна. Хэрэв дарааллын дагуу эрэмбэлж, хуулаагүй бол буцаана. CD/DVD-ний нүүрэнд гүйцэтгэгч байгууллага тамга дарсан байна.

3.10. Ажлын үр дүнг шалгах, хүлээн авах

1. Ажлын үр дүнг шалгах, хүлээн авахад ГХГЗЗГ-ын даргын 2015 оны А/208 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих, үр дүнг үнэлэх, шалгаж хүлээн авах журам”-ыг мөрдөнө.
2. Ажлын үр дүнг хөндлөнгийн шинжээч томилох, түүвэрчлэн шалгах гэсэн 2 хэлбэрээр шалгаж болно.
3. Тухайн жилийн 10 сарын 1-ний өдрөөс өмнө ажлын эцсийн тайланг хүлээлгэж өгөх ба мэргэжлийн хэлтэс 11 сарын 15 гэхэд ажил шалгаж хүлээн авсан дүгнэлтийг гаргасан байна. Хэрэв засвар гарсан бол тухайн зөрчил арилсаны дараа ажил шалгасан дүгнэлтийг гаргана.
4. Бүх засвар хийгдсэний дараа гүйцэтгэгч ажлаа танилцуулга /presentation/ хэлбэрээр 10-15 мин багтаан захиалагчид танилцуулна. Энэ нь 1 багцын хэмжээнд байна.

Танилцуулгын зорилго нь бусад хийсэн ажилтай харьцуулах, сайн болон дутагдалтай талыг харах, ажлын үр дүнг нэгдсэн байдлаар үнэлэхэд чиглэнэ.

Танилцуулганд ажлын зураг, тухайн ажлыг хийсэн арга зүй, хээрийн ажлын маршрут, сансрын зураг боловсруулсан арга зүй, ашигласан материал, хээрийн судалгаанд оролцсон бүрэлдэхүүн, урьд нь хийсэн хянан баталгааны зураг, одоо хийсэн зураг, тэдгээрийн харьцуулалт, дэлгэрэнгүй үзүүлэлт, мониторингийн, бичиглэлийн цэгийн мэдээлэл, нөлөөллийн үзүүлэлт, дүгнэлт, зөвлөмжийг танилцуулна.

5. Ажлыг дутуу хийсэн, чанарын болон бусад доголдол, зөрчил гаргасан тохиолдолд ажил гүйцэтгэх гэрээнд заасны дагуу хариуцлага тооцно.
6. Ажлыг хүлээн авсны дараа Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулж, 1 хувийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын архивт, 1 хувийг орон нутгийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, 1 хувийг сумын Газрын даамлын ажлын хэрэгцээнд шилжүүлнэ.

Монгол орны бэлчээр хадлангийн ангилаа ба өнгөний код

Зураг дээрхи индекс	Ангилалын шифр	Бэлчээр хадлангийн анги, бүлэг, төрөл, төрлүүдийн нэр	Өнгөний код, GIS-RGB
0	1	2	3
	Ө	Өндөр уулын бэлчээр	
	Ө-I	Анги: Уулын царамын ширэгт ялзмагт, хүлэрхэг хөрстэй царам	
	Ө-I-1	Бүлэг төрөл: Хаг-Хөвдөд царам	
1	Ө-I-1-1	Хагт, Хаг-хөвдөт	190-230-255
2	Ө-I-1-2	Боролжтой Зожир өвс-бушилзат, Зожир өвс-хагт	210-220-255
3	Ө-I-1-3	Боролжтой, хөвдөт болон Хөвд-улалжит	190-210-255
	Ө-II	Анги: Уулын царамын хүлрэнцэр ялзмагт, өндөр уулын нугын хар шороорхуу харстэй өндөр уулын нуга	
	Ө-II-1	Бүлэг төрөл: Дэгнүүлт үетэнт	
4	Ө-II-1-1	Бушилз-улалжит, Улалж-бушилзат	110-180-255
5	Ө-II-1-2	Бушилзат	0-170-230
